

20.23 он .11 сар 20 өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

**Оролцогч талуудын хамтын ажиллагааны
удирдлагын төлөвлөгөө батлах тухай**

Говь ХК-ийн оролцогч талуудын хамтын ажиллагааны удирдлагын төлөвлөгөөг тодорхойлон батлах тухай асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13, Компанийн дүрмийн 6.2.7.11 дүгээр заалтыг удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

Нэг. Говь ХК-ийн “Оролцогч талуудын хамтын ажиллагааны удирдлагын төлөвлөгөө”-г Хавсралт-1 ёсоор баталсугай.


Хоёр. Батлагдсан төлөвлөгөөг үйл ажиллагаандаа мөрдөн, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ц.Баатарсайхан/, Тогтвортой хөгжлийн хэлтсийн дарга /Э.Ивгээл/ нарт үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ГЭРЭЛМАА


Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2023 оны 11 сарын 20-ний өдрийн хурлын
35.-р тогтоолын 1 дүгээр хавсралт

	ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	
---	---	--



БАРИМТ БИЧГИЙН НЭР:

**ГОВЬ ХК-ИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

БАРИМТ БИЧГИЙН ХАРИУЦАГЧ	ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС		
БАРИМТ БИЧГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ	КОМПАНИЙН НИЙТ ГАЗАР, НЭГЖ		
БАТЛАГДСАН ОГНОО	2023.11.20		
БАРИМТ БИЧГИЙН НУУЦЛАЛЫН ЗЭРЭГЛЭЛ	НЭЭЛТТЭЙ	БАРИМТ БИЧГИЙН ТҮВШИН	T2

	АЛБАН ТУШААЛ	НЭР	ГАРЫН ҮСЭГ
БАТАЛСАН:	ТУЗ-ИЙН ДАРГА	Д.ГЭРЭЛМАА	
ХЯНАСАН:	ТУЗ-ИЙН ГИШҮҮН	Ц.БААТАРСАЙХАН	
	ТУЗ-ИЙН ГИШҮҮН	Б.АМАРСАЙХАН	
	ТУЗ-ИЙН ГИШҮҮН	Ц.ОРГИЛБОЛД	
	ТУЗ-ИЙН ГИШҮҮН	А.ЖАРГАЛМАА	
	ТУЗ-ИЙН ГИШҮҮН	Д.ХУЛАН	
	ТУЗ-ИЙН ГИШҮҮН	Д.ХҮРЭЛБААТАР	

	<p>ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ</p>	<p>Дугаар: Ж-ТХХ-146-01</p>
---	---	---------------------------------

	<p>ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА</p>	<p>Э.ИВГЭЭЛ</p>	
	<p>ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА</p>	<p>Ц.ЦАСЧИХЭР</p>	
<p>БОЛОВСРУУЛСАН:</p>	<p>ТОГТОЛЦООНЫ АХЛАХ МЕНЕЖЕР</p>	<p>Э.АРИУНЗАЯА</p>	

Улаанбаатар хот
2023 он

	<p style="text-align: center;">ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ</p>	<p style="text-align: right;">Дугаар: Ж-ТХХ-146-01</p>
---	---	--

Баримт бичгийн өөрчлөлтийн бүртгэл			
Хувилбарын дугаар	Хүчин төгөлдөр болсон огноо	Өөрчлөлт оруулж, боловсруулсан албан тушаалтан	Өөрчлөлтийн утга (баримт бичигт ямар өөрчлөлт орсныг товч тайлбарлана)
01	2023.11.20	Тогтолцооны ахлах менежер Э.Ариунзаяа	Баримт бичгийн анхны хувилбар

Баримт бичгийн төлөв		
Эх хувь	Албан хэрэгцээний хувь	Хүчингүй хувь
<div style="border: 1px solid red; padding: 5px; display: inline-block;"> <p style="text-align: center; color: red;">ГОВЬ ХК ЭХ ХУВЬ</p> <p style="font-size: small; color: red;">Гарын үсэг: <i>Ариунзаяа</i> 2023 он 11 сар 21 өдөр</p> </div>		

ИШ ТАТСАН БАРИМТ БИЧГҮҮД		
№	Баримт бичгийн нэр	Бүртгэлийн дугаар
1	ADB шаардлага	2023 он
2		
3		

АГУУЛГА

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	6
1.1 Зорилго.....	6
1.2 Хамрах хүрээ.....	6
1.3 Ерөнхий удирдлагын үүрэг.....	6
2. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ 7	
2.1 Удирдлагын төлөвлөгөөний үйл ажиллагааны зарчим.....	7
2.2 Оролцогч талуудтай хамтран ажиллах удирдлагын зорилго.....	7
2.3 Эрх үүрэг.....	8
3. БАЙГУУЛЛАГЫН МӨРДӨХ СТАНДАРТ	9
3.1 Монгол улсын холбогдох хууль, үндэсний стандартууд.....	9
3.2 Олон улсын холбогдох стандарт, удирдамж.....	9
3.3 Говь ХК-ийн холбогдох стандартууд.....	12
4. ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ХИЙХ, ХАМТРАХ АРГА БАРИЛ	12
4.1 Говь ХК-ийн ерөнхий танилцуулга.....	12
4.2 Нийгэм, эдийн засаг, байгаль орчин.....	14
4.3 Үндсэн оролцогч талууд.....	16
4.4 Эмзэг бүлгийн хүмүүс ба хэлэлцүүлгийн үйл явц.....	17
5. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ АРГА, ХЭРЭГСЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА	18
5.1 Анхан шатны хэлэлцүүлэг, мэдээлэл түгээх арга, хэрэгсэл, үйл ажиллагаа...	18
6. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ГОМДОЛ БАРАГДУУЛАХ, САНАЛ ХҮСЭЛТ ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ ЯВЦ	22

	<p style="text-align: center;">ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ</p>	<p style="text-align: center;">Дугаар: Ж-ТХХ-146-01</p>
---	---	---

6.1	Үйл ажиллагаа	22
7.	УДИРДЛАГЫН ХЯНАЛТ	22
7.1	Удирдлагын хяналт	22
7.2	Хэрэгжүүлэх хуваарь	22
8.	ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ	23
8.1	Хяналт шинжилгээний шаардлага	23
8.2	Шалгуур үзүүлэлт	23
9.	СУРГАЛТ	25
9.1	Сургалтын шаардлага	25
10.	АУДИТ БА ТАЙЛАГНАЛ	25
10.1	Аудит	25
10.2	Тайлагнал	25
11.	ХАВСРАЛТ 1	26
12.	ХАВСРАЛТ 2	29
13.	ХАВСРАЛТ 3	38

	<p style="text-align: center;">ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ</p>	<p style="text-align: center;">Дугаар: Ж-ТХХ-146-01</p>
---	---	---

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Зорилго

- 1.1.1 Говь ХК – ийн Оролцогч талуудын хамтын ажиллагааны удирдлагын төлөвлөгөөг дараах зорилгын хүрээнд тогтооход оршино.
 - 1.1.1.1 Удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээг тогтоох;
 - 1.1.1.2 Үүрэг хариуцлагыг тодорхойлох, тогтоох;
 - 1.1.1.3 Энэхүү төлөвлөгөөнд хамаарах үйл ажиллагаа, төслийн холбогдох стандартуудыг тогтоох;
 - 1.1.1.4 Энэхүү удирдлагын төлөвлөгөөнд хамаарах үйл ажиллагаа, төслийн үүрэг, амлалт, үйл ажиллагааны журам, удирдамжуудыг тогтоох;
 - 1.1.1.5 Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт болон хяналт шинжилгээ, тайлагналын журмыг тодорхойлох;
 - 1.1.1.6 Сургалтын шаардлагуудыг тодорхойлох;
 - 1.1.1.7 Нэмэлт баримт бичиг, мэдээллийн лавлагаа бий болгох;

1.2 Хамрах хүрээ

- 1.2.1 Энэхүү “Оролцогч талуудын хамтын ажиллагааны удирдлагын төлөвлөгөө”-нд тодорхойлсон шаардлагуудыг Говь ХК-ийн бүхий л үйл ажиллагаанд зохих ёсоор болон уг төлөвлөгөөнд тодорхойлсноор хэрэгжүүлнэ.

1.3 Ерөнхий удирдлагын үүрэг

- 1.3.1 Говь ХК-ийн Тогтвортой хөгжлийн хэлтсийн дарга энэхүү удирдлагын төлөвлөгөөг хариуцна.
- 1.3.2 Холбогдох төлөвлөгөө, журамд оруулсан өөрчлөлтийг тусгах зорилгоор заасан хугацаанаас өмнө шинэчлэх шаардлага гарахгүй бол энэхүү Удирдлагын төлөвлөгөөг 3 жил тутам хянан үзэж, өөрчлөлт оруулах, шинэчлэх эсэхийг тодорхойлно.
- 1.3.3 Төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах хүсэлтийг Тогтвортой хөгжлийн хэлтсийн даргад хандан гаргах ба хүсэлтийг Өөрчлөлтийн менежментийн журмын дагуу хянаж, батална.

	<p style="text-align: center;">ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ</p>	<p style="text-align: center;">Дугаар: Ж-ТХХ-146-01</p>
---	---	---

2. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2.1 Удирдлагын төлөвлөгөөний үйл ажиллагааны зарчим

2.1.1 Говь ХК нь бүхий л үйл ажиллагаа, төсөлдөө бүх талуудын оролцоог ижил түвшинд чухалчлан, үйл ажиллагааны ил тод байдлыг эрхэмлэн олон талт ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, нээлттэй бөгөөд харилцан хүндэтгэлтэйгээр санал бодлоо солилцон нийгэм, хүрээлэн буй орчин, оролцогч талуудад болон хийсэн үйлдэл, үр дүндээ хариуцлагатай хандаж, тогтвортой хөгжлийн зорилгод тэмүүлж ажиллана.

2.2 Оролцогч талуудтай хамтран ажиллах удирдлагын зорилго

2.2.1 Үйлдвэр, үйл ажиллагааны ойролцоох оршин суугч иргэд, бэлтгэн нийлүүлэгчид болон малчид, хэрэглэгч, төр захиргааны байгууллага, судалгаа шинжилгээний байгууллага, төрийн бус байгууллага, хөрөнгө оруулагчид, банк санхүүгийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудтай харилцан итгэлцэл, нээлттэй ил тод байдал, нэгдмэл сонирхолд үндэслэсэн тогтвортой харилцаа бий болгоно.

2.2.2 Бэлтгэн нийлүүлэгч, малчдын чадавхыг бэхжүүлж, уламжлалд суурилсан байгальд ээлтэй, хүний эрхийг дээдэлсэн ахуй соёлын мэдлэгийг бий болгох, хамтын ажиллагааг идэвхтэй хөгжүүлнэ.

2.2.3 Зорилгын хүрэн дэх зорилтуудыг дараах байдлаар тодорхойлно.

2.2.3.1 Оролцогч талуудын идэвхтэй хамтын ажиллагааг хангахад чиглэсэн зохих стандартыг тогтоох;

2.2.3.2 Оролцогч талууд, тэдний сонирхол, санаа зовоосон гол асуудлыг тодорхойлох;

2.2.3.3 Талуудын оролцоог хангах хэлэлцүүлгийн арга барил, шаардлагуудыг тодорхойлох;

2.2.3.4 Талуудын оролцоог цаашид хангахад тусгайлан чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах;

2.2.3.5 Оролцогч талуудын санал хүлээж авах, гомдол барагдуулах, маргаан шийдвэрлэх журмын хэрэгжилтийг хангах;

2.2.3.6 Үүрэг хариуцлагыг тодорхойлох;

2.2.3.7 Хяналт шинжилгээ хийх, тайлагнах журмыг тодорхойлох;

2.2.3.8 Сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох.

	<p style="text-align: center;">ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ</p>	<p style="text-align: center;">Дугаар: Ж-ТХХ-146-01</p>
---	---	---

2.2.4 Бусад удирдлагын төлөвлөгөө болон ижил төстэй баримт бичигтэй уялдах уялдааг дараах байдлаар тодорхойлно.

2.2.4.1 Тус төлөвлөгөө нь шийдвэр ба үйл явцад нөлөөлж чадах, нөлөөнд автах эсхүл өөрийн хандлагаар нөлөөлдөг талуудын оролцоог хангах өргөн хүрээтэй үйл ажиллагааны үндэс болох тул бусад удирдлагын төлөвлөгөөтэй харилцан уялдаатай хэрэгжинэ.

2.3 Эрх үүрэг

2.3.1 Говь ХК-ийн Тогтвортой хөгжлийн хэлтсийн дарга тус төлөвлөгөөний хэрэгжилтийг ерөнхийд нь хариуцна. Төлөвлөгөөтэй холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг дараах хэлтсүүдэд хуваарилан хариуцуулсан байна.

2.3.1.1 Тогтвортой хөгжлийн хэлтсийн үүрэг

- Үйлдвэрийн ойролцоох оршин суугчид, төрийн ба төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллага, судалгаа шинжилгээний байгууллага болон эмэгтэйчүүд, охид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, үндэсний цөөнх зэрэг эрх нь зөрчигдөх өндөр эрсдэлтэй бүлгүүдийн оролцогч талуудын хамтын ажиллагааг хангах үүрэгтэй.
- Тогтвортой хөгжлийн хэлтсийн дарга нь ОТХАУТ-г боловсруулж хэрэгжүүлэх, оролцогч талуудын харилцаа холбоо, хамтын ажиллагааны төлөвлөгөө батлах, оролцогч талуудтай хамтран ажиллах чиглэлээр стратегийн удирдлагаар хангах асуудлыг хариуцаж ажиллана.
- Тогтвортой хөгжлийн менежер /Нийгэм/ нь тус төлөвлөгөөний ажлуудыг хэрэгжүүлэх, тухайлан байгуулсан гэрээ, хэлцлийн хүрээнд хэрэгжүүлж буй хамтын ажиллагаатай холбоотой үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй.
- Тогтолцооны менежер нь тус төлөвлөгөөний хяналт, үнэлгээг хариуцан, удирдлагын хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

2.3.1.2 Дотоод борлуулалт, маркетингийн хэлтийн үүрэг

- Дотоод борлуулалт, маркетингийн хэлтэс нь хэрэглэгч, үйлчлүүлэгч, сурталчилгааны гэрээт гүйцэтгэгч болон хэвлэл мэдээллийн талуудын хамтын ажиллагааг хангах үүрэгтэй.
- Оролцогч талуудын хамтын ажиллагааны бүхий л асуудлаар ТХХ-тэй нягт хамтарч ажиллана.

	<p style="text-align: center;">ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ</p>	<p style="text-align: center;">Дугаар: Ж-ТХХ-146-01</p>
---	---	---

2.3.1.3 Хөрөнгө бүртгэлийн албаны үүрэг

- Хөрөнгө бүртгэлийн алба нь бэлтгэн нийлүүлэгч талууд тухайлбал малчин, хоршоо, аж ахуйн нэгжүүдийн хамтын ажиллагааг хангах үүрэгтэй.
- Оролцогч талуудын хамтын ажиллагааны бүхий л асуудлаар ТХХ-тэй нягт хамтарч ажиллана.

3. БАЙГУУЛЛАГЫН МӨРДӨХ СТАНДАРТ

3.1 Монгол улсын холбогдох хууль, үндэсний стандартууд

3.1.1 Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012 он)

3.1.1.1 2012 оны 6 дугаар сарын 23-ны өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний (БОНБУ) тухай хуулийн нэмэлт өөрчлөлт оруулсан хувилбар нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний асуудлыг хөндсөн бөгөөд уг хуульд зааснаар аливаа тусгай төсөл хэрэгжүүлэгч, үйл ажиллагаа эрхлэгч нь БОНБНУ-г эрх бүхий байгууллагаар хийлгэж, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг агуулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй байхыг шаарддаг.

3.1.1.2 БОНБНУ-ний үйл явцад төсөл хэрэгжүүлэх газрын иргэд, төр болон бусад талуудын оролцоог хангах талаар уг хуульд нарийвчлан заасан. Тус хуулийн 18.4-т төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна гэж заадаг.

3.1.1.3 Гэхдээ орон нутгийн иргэдийн саналыг төлөвлөлт болон үйл ажиллагаанд хэрхэн тусгах талаар уг хуульд нарийвчлан заагаагүй байдаг.

3.2 Олон улсын холбогдох стандарт, удирдамж

3.2.1 ГОВЬ ХК нь НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн чиглэлээр баримтлах зарчмууд, Азийн хөгжлийн банк (АХБ), Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК), Европын сэргээн босголт, хөрөнгө оруулалтын банкнаас (ЕСБХБ) батлан гаргасан олон улсын стандарт, удирдамжууд зэргийг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлдэг.

	<p style="text-align: center;">ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ</p>	<p style="text-align: center;">Дугаар: Ж-ТХХ-146-01</p>
---	---	---

3.2.1.1 НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн чиглэлээр баримтлах зарчмууд:

Бизнес ба хүний эрхийн чиглэлээр баримтлах зарчмуудад бизнесийн байгууллагууд, аж ахуйн нэгжүүд нь холбогдох бүх хууль тогтоомжийг дагаж мөрдөх, хүний эрхийг хүндэтгэх, зөрчигдсөн эрхийг сэргээж эдлүүлэх зохистой арга хэмжээ авах үүрэгтэй бөгөөд хүндэтгэх үүргээ биелүүлэхийн тулд эдгээрээс дараах зүйлсийг биелүүлэхийг шаарддаг.

Үүнд:

- Өөрсдийн бизнесийн үйл ажиллагаагаараа дамжуулан хүний эрх зөрчих, эсвэл хүний эрх зөрчихөд дам нөлөө үзүүлэхээс зайлсхийх, хүний эрхийн сөрөг нөлөөлөл үүссэн тохиолдолд түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ авах;
- Өөрсдийн бизнесийн үйл ажиллагаагаараа дамжуулан хүний эрхийн сөрөг нөлөөлөл үүсэхэд дам нөлөө үзүүлээгүй ч бизнесийн түншүүдийн үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээнээс шууд үүдэлтэйгээр үүссэн хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эсвэл уг зөрчлийн нөлөөллийг бууруулах, арилгахын тулд хүчин чармайлт гаргах;

3.2.1.2 Азийн хөгжлийн банкны Хамгаалалтын бодлогын мэдэгдэл (2009он):

Азийн хөгжлийн банкны Хамгаалалтын бодлогын мэдэгдэл нь байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлын төлөөх амлалтын талаарх өргөн хүрээний мэдэгдлийг агуулсан бөгөөд бодлогын гурван зорилтыг дараах байдлаар тодорхойлсон.

- Боломжтой бол төслийн байгаль орчин, нөлөөлөлд өртсөн хүмүүст үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлсхийх;
- Зайлсхийх боломжгүй үед төслийн хүрээлэн буй орчин болон нөлөөлөлд өртсөн хүмүүст үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах ба /эсвэл нөхөн олговор олгох;
- Зээлдүүлэгч байгууллагад хамгаалалтын системээ бэхжүүлэх, байгаль орчин, нийгмийн эрсдэлийг удирдах чадавхыг хөгжүүлэхэд нь туслах, төслийн бүхий л үе шатанд олон нөлөөлөлд өртсөн эсвэл өртөх боломжтой, бусад холбогдох талуудтай мэдээлэл солилцон, зөвлөлдөж хамтран ажиллахыг шаардлага болгох;

- Төслийн байгаль орчин, нийгмийн хамгааллын төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах, үнэлэхэд төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүстэй зөвлөлдөх, тэдний оролцоог хангах механизмыг оруулахад онцгой ач холбогдол өгдөг байх;
- Оролцогч талуудтай хүртээмжтэй зөвлөлдөх үйл явц нь (i) төслийн бэлтгэлийн эхний шатанд эхэлж, төслийн мөчлөгийн туршид тасралтгүй явагддаг; (ii) нөлөөлөлд өртсөн хүмүүст ойлгомжтой, хүртээмжтэй, холбогдох, хангалттай мэдээллийг цаг тухайд нь нээлттэй болгох; (iii) айлган сүрдүүлэх, албадлагагүй орчинд явагдах; (iv) жендэрийн тэгш байдлыг хангасан, мэдрэмжтэй, эмзэг бүлгийн болон эмзэг бүлгийн хэрэгцээнд тохирсон байх; ба (v) төсөл боловсруулах, нөлөөллийг бууруулах арга хэмжээ, хөгжлийн үр өгөөж, боломжуудыг хуваалцах, хэрэгжүүлэх асуудлууд зэрэг нөлөөлөлд өртсөн хүмүүс болон бусад оролцогч талуудын холбогдох бүх санаа бодлыг шийдвэр гаргахад тусгах боломжийг олгох;
- Хэлэлцүүлгийг нөлөөлөлд өртсөн ард иргэдэд үзүүлэх нөлөөлөлтэй уялдуулан явуулна. Хэлэлцүүлгийн үйл явц болон түүний үр дүнг байгаль орчин, нийгмийн үнэлгээний тайлан, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө, уугуул иргэдийн төлөвлөгөөнд тусгаж, баримтжуулах;

3.2.1.3 Олон улсын санхүүгийн корпорацийн байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлын гүйцэтгэлийн стандарт (2012он): ОУСК-н Нийгэм, байгаль орчны тогтвортой байдлын стандарт (Гүйцэтгэлийн стандарт 1 (2012 он) нь Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах үйл ажиллагааны талаар дараах зөвлөмжүүдийг гаргасан байна. Үүнд:

- “Нийгэм, байгаль орчны удирдлагын үр дүнтэй систем нь ... захиалагч, түүний ажилчид ба төслийн нөлөөлөлд шууд өртсөн орон нутгийн иргэдийн хоорондын харилцааг тусгасан байна”;
- “Өөрсдөд нь нөлөөлж болзошгүй үйл ажиллагааны асуудал дээр уг нөлөөлөлд өртөх орон нутгийн иргэдийн оролцоог зохих ёсоор хангах”;
- “Сул тал, эмзэг байдлаасаа шалтгаалаад төслийн нөлөөлөлд өөр өөр байдлаар буюу харилцан адилгүйгээр өртөх хувь хүмүүс болон бүлгүүдийг олж тогтоох”;

	<p style="text-align: center;">ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ</p>	<p style="text-align: center;">Дугаар: Ж-ТХХ-146-01</p>
---	---	---

- “Орон нутгийн иргэдийн оролцоог хангах гэдэг нь захиалагчийн зүгээс мэдээллийг ил тод болгох тасралтгүй үйл явц юм”;
- Орон нутгийн иргэд төслийн эрсдэл, сөрөг нөлөөлөлд өртөх тохиолдолд оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах хүрээнд тэдэнтэй хэлэлцүүлэг хийх;
- “Орон нутгийн иргэдийн оролцоог хангах нь орон нутгийн иргэдтэй урт хугацааны, үр дүнтэй харилцаа бий болгож түүнийгээ хадгалах зорилготой”;
- “Орон нутгийн иргэдийн оролцоог хангах үйл ажиллагааны төрөл, давтамж нь нөлөөлөлд өртөх орон нутгийн иргэдэд учирч буй эрсдэл, сөрөг нөлөөлөлд тохирсон байна”;

3.3 Говь ХК-ийн холбогдох стандартууд

3.3.1 Говь ХК нь бизнесийн үйл ажиллагаандаа бүхий л оролцогч талуудын эрх ашгийн тэнцвэртэй байдлыг хангахыг засаглалын бодлогынхоо зорилт болон зарчимд тусгасан. Үүнд:

- 3.3.1.1 “Олон нийтэд хүргэх мэдээллийн журам” нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, олон нийт болон бусад оролцогч талуудыг компанийн талаар үнэн зөв мэдээллээр цаг хугацаанд нь хангах зорилготой.
- 3.3.1.2 “Оролцогч талуудын өргөдөл, санал гомдол хүлээн авах, шийдвэрлэх журам”-аар оролцогч талуудын оролцоог хангаж, санал хүсэлт болон өргөдөл гомдлыг хүлээн авах шийдвэрлэх процессыг зохицуулдаг.
- 3.3.1.3 “Шүгэл үлээгч тогтолцооны үйл ажиллагааны журам”-аар оролцогч талуудтай үр ашигтай харилцааг нэмэгдүүлж, байгууллагын үйл ажиллагааны ёс зүйн доголдлыг эрт үед илрүүлж, гарч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, засаж сайжруулах, талуудын итгэлийг бэхжүүлэх, бизнесийн тогтвортой хөгжлийг дэмжих үйл ажиллагааг зохицуулдаг.

4. ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ХИЙХ, ХАМТРАХ АРГА БАРИЛ


4.1 Говь ХК-ийн ерөнхий танилцуулга

4.1.1 Говь ХК-ийн үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаа нь Улаанбаатар хотын Хан-уул ба Баянгол дүүрэгт, дэлгүүрүүд нь Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэг (Зураг 1), Дархан-Уул аймгийн Дархан суманд төвлөрөн явагдаж байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1 Говь ХК-ийн үйл ажиллагааны байршил


№	Үйл ажиллагааны төрөл	Байршил
1	Говь үйлдвэр ба үйлдвэрийн дэлгүүр	Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хороо
2	Говь -2 үйлдвэр	Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20-р хороо
3	Галлерей төв дэлгүүр	Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 8-р хороо
4	Дархан салбар дэлгүүр	Дархан уул аймгийн Дархан сум

Зураг 1 Үйл ажиллагааны байршил



4.1.2 Говь ХК-ийн үндсэн бэлтгэн нийлүүлэгчид нь Дорнод, Баянхонгор, Хэнтий, Сүхбаатар, Хөвсгөл, Увс, Завхан, Ховд аймгуудад тархан суудаг. (Зураг 2)

Зураг 2 Үндсэн бэлтгэн нийлүүлэгчдийн байршил



4.2 Нийгэм, эдийн засаг, байгаль орчин

4.2.1 Газар зүй, уур амьсгал, байгаль орчин

4.2.1.1 Газар зүй

- Улаанбаатар хот нь Хэнтийн нурууны урд үзүүр болох Баянзүрх, Богд хан, Сонгино хайрхан, Чингэлтэй хайрхан уулсаар зүүн, урд, баруун, хойд талаараа тус тус хүрээлэгдсэн бөгөөд Түүл, Сэлбэ голуудын бэлчир хөндийд байрладаг. Дунджаар далайн түвшнээс дээш 1351 м өндөрт оршдог. Нийт 4,704.4 км² нутагтай.

4.2.1.2 Уур амьсгал

- Улаанбаатар нь маш өндөр газарт, харьцангуй өндөр өргөрөгт, ямар ч эргээс хэдэн зуун километр зайтай оршдог зэрэг шалтгаанаас болж дэлхийн хамгийн хүйтэн нийслэлд тооцогддог. Жилийн дундаж температур нь -1.3 °C. Богино, дулаан зунтай бөгөөд урт, маш хүйтэн, хуурай өвөлтэй. Жилийн дундаж хур тунадас нь 242.7 мм, дундаж чийгшилт нь 69%.

4.2.2 Нийгэм, эдийн засаг

4.2.2.1 Нийгэм

- Говь ХК-ийн үндсэн үйлдвэр нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хорооны үйлдвэрийн бүсэд байрладаг.
- 2022 оны жилийн эцсийн байдлаар Хан-Уул дүүрэгт 63967 өрхөд 238511 иргэн амьдарч байна. Хүн амын 47.4% эрэгтэй, 52.6%

эмэгтэйчүүд байна. 3-р хороололд 3956 өрхөд 15285 иргэн оршин суудаг. Хан-Уул дүүргийн хүн амын нэлээд хэсэг буюу 64.9 хувийг 35 хүртэлх насны хүүхэд залуучууд эзэлдэг бөгөөд үүний 36.4 хувийг 0-15 насны хүүхэд, 55.8 хувийг 16-59 насны хүүхэд, 7.8 хувийг өндөр настан эзэлдэг. 60 ба түүнээс дээш настай.

- Хан Уул дүүрэгт 2022 оны эцсийн байдлаар 2351 өрх толгойлсон иргэн байгаагийн 85.5 хувийг эмэгтэйчүүд эзэлж, өмнөх оноос 5.7 хувиар буурсан байна. Мөн тус дүүрэгт хөгжлийн бэрхшээлтэй 4494 иргэн бүртгэгдсэн нь өмнөх оноос 440 (10.8%)-аар нэмэгдсэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 46.0 хувийг эмэгтэйчүүд, 16.3 хувийг 0-17 насны хүүхдүүд эзэлж байна. Зөвхөн 3-р хороонд л гэхэд 313 хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртгэгдсэний 156 нь эмэгтэйчүүд байна.
- Дүүргийн хэмжээнд хөдөлмөр эрхэлж буй иргэдийн тоо 78399, ажилгүй 5038 иргэн байна. Ажилгүйдлийн түвшин 2021 онд 8% байсан бол 2022 онд 6% болж буурсан.
- Түүх, соёлын өв, археологийн дурсгалын тухайд Говь 1 бүсэд ийм байгууламж бүртгэгдээгүй байна. Хамгийн ойр байрлах суурьшлын бүс нь зүүн талаараа 1.5 км-т орших Алтай хотхон бөгөөд бусад зэргэлдээх бүсүүдэд хөнгөн үйлдвэрийн үйлдвэр, агуулах, цехүүд багтдаг.
- Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20-р хорооны аж үйлдвэрийн бүсэд стратегийн ач холбогдолтой ноолууран зэрэх үйлдвэр Говь 2 байрладаг. Баянгол дүүрэг 2021 оны эцсийн байдлаар 63967 өрхөд оршин суудаг 236385 хүн амтай. Энэ хүн амын 47.0% эрэгтэй, 53% эмэгтэйчүүд байна. Тодруулбал, 20 дугаар хороололд 3050 өрхөд тархсан 10609 оршин суугч бий.
- Дүүргийн ажиллах хүчинд нийт 78399 хөдөлмөр эрхэлж буй иргэн хамрагдаж байгаагийн 837 нь ажилгүйдлийн ангилалд багтаж байгаагийн 465 (55.4%) нь эмэгтэйчүүд байна. 2022 онд ажилгүйдлийн түвшин өмнөх онтой харьцуулахад 1.8 дахин өссөн нь анхаарал татаж байна.
- Говь 2-ын ойр орчимд түүх, соёл, археологийн дурсгалт газрууд байхгүй. Үндсэн үйлдвэрээс 2.5 км-ийн зайд байрладаг тус бүсэд 5 км-

ийн радиуст суурьшлын бүс байхгүй. Харин барилгын материалын үйлдвэрлэлийн байгууламж, ложистикийн цехүүд хаяа дэрлэн оршдог.

4.2.2.2 Эдийн засаг

- Улаанбаатар хот нь үндэсний хамгийн их үйлдвэрлэл үйлчилгээ төвлөрсөн бүс болдогт бөгөөд одоогоор 40000 орчим том жижиг компаниуд Монгол улсын Дотоодын нийт бүтээгдэхүүний 46%-ийг үйлдвэрлэж байна. Зам тээвэр, инженерийн иж бүрэн дэд бүтэц сайн хөгжсөн.

4.3 Үндсэн оролцогч талууд

4.3.1 Говь ХК нь 2022 оноос эхлэн үйл ажиллагааны нөлөөлөлд шууд болон шууд бус байдлаар өртөх магадлалтай, эсвэл үйл ажиллагааг сонирхсон талуудтай байгууллагын болон иргэдийн түвшинд ажил хэрэгч, хүртээмжтэй, итгэлцэлт харилцааг цогцоор авч үзэн оролцогч талуудыг тодорхойлж, зураглал гаргах ажлыг хийж эхэлж байна.

4.3.2 ОТХАУТ-г боловсруулан, баталгаажуулах ажлын хүрээнд Орон нутаг, оролцогч талуудын хамтын ажиллагааны удирдамжийг (Хавсралт А) боловсруулж, хэрэгжилтийг ханган оролцогч талуудын харилцаа, хамтын ажиллагааг Хамтын ажиллагааны нэгдсэн бүртгэлд оруулахаар ажиллаж байна.

4.3.3 **Талуудын ангилал:** Оролцогч талуудыг ГОВЬ ХК-н зүгээс НҮБ-н Бизнес ба хүний эрхийн чиглэлээр баримтлах зарчмуудын хүрээнд хүний эрхийг хүндэтгэх үүргийн чиглэлээр компанийн үйл ажиллагааны улмаас нийгэм, эдийн засаг, байгаль орчны нөлөөлөлд ямар нэг байдлаар өртсөн газар нутагт оршиж буй болон түүний ойр орчмын оршин суугчид ба тодорхой шийдвэр гаргахад оролцох сонирхолтой буюу түүнд нөлөөлж чадах эсвэл тэрхүү шийдвэрийн нөлөөнд өртөх хувь хүмүүс, хэсэг бүлэг хүмүүсийн төлөөлөл гэсэн 2 бүлэгт авч үзсэн.

4.3.3.1 Говь ХК-ийн үйл ажиллагааны нөлөөлөлд шууд, дам байдлаар, шууд бусаар өртөх бүлгүүд:

- Үндсэн болон гэрээт ажилтнууд;
- Үйлдвэрийн үйл ажиллагааны ойр орчим оршин суугч иргэд, байгууллагын ажилтнууд;
- Бэлтгэн нийлүүлэгчид (малчин, хоршоо, компани)
- Гэрээт гүйцэтгэгчид, тэдний ажилтнууд;
- Үйлчлүүлэгчид, хэрэглэгчид;

4.3.3.2 Бусад оролцогч талууд:

- Төр, захиргааны байгууллагууд;
- Төрийн бус, иргэний нийгмийн байгууллагууд;
- Мэргэжлийн холбоод;
- Соёл, боловсролын байгууллагууд;
- Бизнесийн түншүүд, ЖДҮ;
- Хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид
- Банк, санхүүгийн байгууллагууд;
- Олон улсын байгууллагууд;
- Хэвлэл мэдээллийн байгууллагууд;

4.3.3.3 Үндсэн оролцогч талуудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийн багцыг Хавсралт №1-т оруулсан.**4.4 Эмзэг бүлгийн хүмүүс ба хэлэлцүүлгийн үйл явц**

4.4.1 Олон улсын санхүүгийн корпорацын байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн стандарт (2012)-н хүрээнд хүйс, гарал үүсэл, нас, бие махбодын болон сэтгэцийн гаралтай хөгжлийн бэрхшээл, эдийн засгийн дорой байдал, нийгмийн байдлаасаа шалтгаалан төслийн сөрөг нөлөөлөлд бусдаас илүү өртсөн байж болзошгүй, эрхээ хамгаалах боломжоосоо шалтгаалан хөгжлийн үр ашгаас хүртэх боломж нь хязгаарлагдмал хүмүүсийг эмзэг бүлгийн хүмүүс гэж авч үзсэн.

4.4.2 2012 онд батлагдсан Нийгмийн хамгааллын тухай хуульд “Эмзэг бүлгийн хүмүүс” гэдэгт өндөр настан, хүнд нөхцөлд амьдарч буй хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, тогтмол асаргаа шаардлагатай хүмүүс, 18 хүртэлх насны өнчин хүүхэд, өрх толгойлсон ганц бие эцэг/эхчүүдийг ойлгоно.

4.4.3 Дүүргийн хөдөлмөр, нийгмийн халамжийн хэлтэс сумын иргэдийн нийгмийн байдлыг үнэлэхэд тусгай аргачлал ашигладаг. Компани нь орон нутгийн засаг захиргаа, орон нутгийн удирдлагуудтай уулзалт арга хэмжээ зохиох замаар дүүрэг, хорооны эмзэг бүлгийн иргэдийг дэмжин хамтран ажиллах үйл явцыг тодорхойлно.

4.4.4 Монгол Улсын Засгийн газрын эмзэг байдлын шалгуур үзүүлэлтүүдийн бүлэг:

4.4.4.1 ганц бие, өрх толгойлсон иргэд;

4.4.4.2 байнгын асаргаа сувилгаа шаарддаг өрхийн гишүүн;

4.4.4.3 олон хүүхэдтэй;

4.4.4.4 ажилгүй;

	<p style="text-align: center;">ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ</p>	<p style="text-align: center;">Дугаар: Ж-ТХХ-146-01</p>
---	---	---

4.4.5 Хүний эрх талаас нь харах юм бол Байгууллага, Төр нь үүрэг хүлээгч, бусад оролцогч талууд эрх эдлэгч юм. Тиймээс оролцогч талуудад эмэгтэйчүүд, охид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, үндэсний цөөнх зэрэг эрх нь зөрчигдөх өндөр эрсдэлтэй бүлгүүдэд Говь ХК онцгойлон анхаардаг.

5. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ АРГА, ХЭРЭГСЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

5.1 Анхан шатны хэлэлцүүлэг, мэдээлэл түгээх арга, хэрэгсэл, үйл ажиллагаа

- 5.1.1 Говь ХК нь үр дүнтэй хэлэлцүүлэг явуулахын тулд орон нутгийн оролцоог хангах төрөл бүрийн арга, аргачлал ашигладаг. Хүртээмжтэй, үр дүнтэй оролцоог хангахын тулд үндсэн үйл ажиллагааны цаг үеийн мэдээллийг хүртээмжтэй түгээх, аливаа төсөл хөтөлбөр шинээр эхлүүлэхэд техник эдийн үндэслэл, байгаль орчин нийгмийн нөлөөллийн үнэлгээ болон бусад холбогдох судалгаа хийхдээ оролцогч талуудтай мэдээлэл солилцож үйл явцад татан оролцуулж, санаа бодлыг нь тусгах хэлэлцүүлэг, хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлнэ.
- 5.1.2 Компани оролцогч талуудын санал, дүгнэлтэд үндэслэн хамтын ажиллагааны үр ашигт тогтмол үнэлгээ хийнэ.
- 5.1.3 Оролцогч талуудтай хамтран ажиллаж буй үндсэн аргууд нь:
- 5.1.3.1 Монгол Улсын Засгийн газартай хийх уулзалт, зөвлөгөөн;
 - 5.1.3.2 Засгийн газрын шинэчилсэн мэдээлэл, шуурхай зөвлөгөөн;
 - 5.1.3.3 Үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцуулах нээлттэй хаалганы өдөр зохион байгуулах;
 - 5.1.3.4 Бэлтгэн нийлүүлэгчидтэй сэдэвчилсэн уулзалт, сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах;
 - 5.1.3.5 ТББ, сонирхлын бүлгүүдтэй хийх тогтмол уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах;
 - 5.1.3.6 Хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээгээр үйл ажиллагааг сурталчлан таниулах;
 - 5.1.3.7 Мэдээллийн хуудас, сонин, сэтгүүлд нийтлэл гаргах;
 - 5.1.3.8 Компанийн цахим хуудасны хүртээмжийг сайжруулах;
- 5.1.4 Хүснэгт 2-т оролцогч талуудтай харилцахад ихэвчлэн ашигладаг гол арга хэрэгслүүдийг харуулав.

Хүснэгт 2 Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах, мэдээлэл түгээх аргууд

Д/д	Оролцогч талууд	Харилцааны үр өгөөж	Хариуцагч нэгж	Мэдээлэл түгээх аргууд
1.	Хэрэглэгчид (дотоод, гадаад, онлайн)	Бизнес болон түүний үйлчлүүлэгчид эсвэл худалдан авагчдын хооронд утга учиртай, интерактив харилцаа холбоог бий болгоход чиглэсэн стратеги, санаачилгууд дээр төвлөрнө. Энэ нь харилцаа холбоог хөгжүүлэх, онцгой туршлагыг бий болгох, ГОВЬ-иар таатай аялах нөхцөлийг бүрдүүлж, үйлчлүүлэгчдийг татан оролцуулж, тэдний сэтгэл ханамжийг хангах технологийг ашиглах.	Борлуулалтын газрууд	Сурталчилгаа, шинэ бүтээгдэхүүний шоу, санал авах цахим уулзалт, үйлдвэрийн үйл ажиллагаа танилцуулах нээлттэй хаалганы өдөр, цахим хуудас
2.	Хөрөнгө оруулагчид (хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагч, ТУЗ)	Нээлттэй харилцаа холбоо, ил тод тайлан, идэвхтэй оролцоо нь итгэлцлийг бий болгох, хөрөнгө оруулалт татах, оролцогч талууд болон компанийн аль алинд нь урт хугацааны үнэ цэнийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулна.	ТУЗ-ийн ажлын алба	Гүйцэтгэлийн тайлан хүргүүлэх, ганцаарчилсан болон бүлгийн уулзалт, жилийн тайлангийн хурал
3.	Санхүүгийн байгууллагууд (банк, банк бус санхүүгийн байгууллага, сан гм..)	Үйл ажиллагааг оновчтой болгох, инновацид хөрөнгө оруулалт хийх, шинэ боломжуудыг ашиглахын тулд хүчтэй түншлэлийг бий болгох, санхүүжилтийг баталгаажуулах, санхүүгийн туршлагаа ашиглах зорилгоор бизнесээ өргөжүүлэх санхүүгийн байгууллагуудтай стратегийн хамтын ажиллагаа.	СУГ	Ганцаарчилсан уулзалт, цахим хуудас, семинар
4.	Төрийн байгууллагууд (яамд, агентлаг, алба, хэлтэс, ИТХ, ЗД)	Хамтарсан зорилго, бодлого, төслүүд дээр хамтран ажиллахын тулд орон нутгийн, бүс нутгийн, үндэсний зэрэг янз бүрийн түвшний төрийн байгууллагуудтай хамтран ажиллана. Энэ нь зэрэг үр дүнд хүрэх, нийгэмд тулгарч буй сорилтуудыг шийдвэрлэх, патент, хуулбарлах эрх, хууль тогтоомжийг дагаж мөрдөхийн тулд үр бүтээлтэй харилцаа тогтоох, харилцан ашиг сонирхлыг хамгаалах,	ТХХ ба бусад газар нэгжүүд өөрсдийн үйл ажиллагааны чиглэлээр	Олон нийтийн уулзалт, цахим хуудас, нийгмийн сүлжээний сувгууд

		засгийн газрын нөөц, туршлагаас ашиглах ач холбогдолтой		
5.	Үйлдвэрийн ойролцоо оршин суугч иргэд	Мэдээллийг ил тод хуваалцах, зэрэг өөрчлөлтийг бий болгох, нэгдмэл зорилгын мэдрэмжийг бий болгохын тулд олон нийттэй хамтран ажиллах, уур амьсгалын өөрчлөлт, ногоон хөгжлийн талаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаа	ТХХ ба бусад газар нэгжүүд өөрсдийн үйл ажиллагааны чиглэлээр	Олон нийтийн уулзалт, хэлэлцүүлэг, цахим хуудас, нийгмийн сүлжээний сувгууд, нээлтэй хаалганы өдөр
6.	Бизнесийн түншүүд, зах зээлийн өрсөлдөгчид	Инновацыг бий болгох, шилдэг туршлагыг хуваалцах, эрүүл өрсөлдөөнийг хадгалахын тулд салбараа хамтдаа урагшлуулахын тулд бизнесийн түншүүд болон өрсөлдөгчдийн оролцоог хангах. Энэ нь өсөлт, дэвшлийг дэмжихэд мэдлэг солилцох, стратегийн түншлэл, хамтын ажиллагааны санаачилгыг хөгжүүлнэ.	ТХХ ба бусад газар нэгжүүд өөрсдийн үйл ажиллагааны чиглэлээр	Бага хурал, хэлэлцүүлэг, туршлага солилцох аялал
7.	Бэлтгэн нийлүүлэгчид (малчин, хоршоо, компани)	Тогтвортой түншлэлийг дэмжих: Түүхий эдийн хариуцлагатай эх үүсвэрийг хангах, шударга худалдааны практикийг дэмжих, хамтын үнэ цэнийг бий болгох зорилгоор түүхий ноолуур бэлтгэн нийлүүлэгч хоршоодтой хамтын ажиллагаагаа бэхжүүлэх. Энэ сэдвийн хүрээнд ил тод, нээлттэй харилцаа холбоо, чадавхыг бэхжүүлэх санаачилга, урт хугацааны түншлэл нь хоёр талын харилцан өсөлт, тогтвортой байдлыг бүрдүүлнэ	ТХХ, Хөрөнгө бүртгэлийн алба	Сургалт, үйлдвэр үйл ажиллагаа танилцуулах нээлттэй хаалганы өдөр, зорилтот бүлгийн хэлэлцүүлэг, чадавхжуулах хөтөлбөр
8.	Гэрээт гүйцэтгэгчид	Говь компанийн нийлүүлэлтийн сүлжээгээрээ тогтвортой байдлыг хангахад чиглэсэн хамтын хүчин чармайлтыг онцолж, ёс зүйн практикийг	ХАХ	Ганцаарчилсан хэлэлцүүлэг, санал

		бий болгох, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, хариуцлагатай эх үүсвэрийг хангах зорилгоор гүйцэтгэгч, ханган нийлүүлэгчидтэй идэвхтэй хамтран ажиллах зорилгоор гүйцэтгэгч, ханган нийлүүлэгчидтэй хамтран ажиллах.		асуулга, зорилтот бүлгийн семинар, ханган нийлүүлэгчдийг хөгжүүлэх хөтөлбөр
9.	Иргэний нийгмийн байгууллагууд, мэргэжлийн холбоод	Нийгэмд тулгарч буй сорилтуудыг шийдвэрлэх, бодлого боловсруулах, хамтын туршлага, нөлөөллийн хүчин чармайлт, стратегийн түншлэл ба олон нийтэд утга учиртай нөлөөллийг бий болгоход мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагуудыг татан оролцуулах, дэмжлэг авах.	ТХХ ба бусад газар нэгжүүд өөрсдийн үйл ажиллагааны чиглэлээр	Үйлдвэрийн үйл ажиллагаа танилцуулах нээлттэй хаалганы өдөр, сэдэвчилсэн семинар, ганцаарчилсан уулзалт, хамтарсан төсөл хөтөлбөр
11.	Хэвлэл мэдээлэл	Брэндийн харагдах байдал, харилцаа холбооны нөлөөллийн хувьд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй үр дүнтэй ажиллах нь бизнес болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн динамик харилцан үйлчлэлд төвлөрдөг. Энэ нь Говь компанийн брэндийн харагдцыг нэмэгдүүлэх, гол мессежүүдийг хүргэх, олон нийтийн ойлголтод нөлөөлөхийн тулд хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй хэрхэн стратегийн холбоотой ажиллаж байгааг судлахад нөлөөтэй.	Гадаад болон Дотоод маркетинг	Ярилцлага, нэвтрүүлэг, контент боловсруулах, сонин сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэх, цахим хуудас, олон нийтийн соён гэгээрлийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх
12.	Эмзэг бүлэг	Нийгэмшихэд хувь нэмрээ оруулах, жендэрийн эрх тэгш боломжийг олгох, мэдээллийг сайжруулах	Гадаад болон дотоод маркетинг, Контент хөгжүүлэлтийн хэлтэс, Тогтвортой хөгжлийн хэлтэс ХНГ	Зорилтот бүлгийн хэлэлцүүлэг, сургалт, төсөл хөтөлбөр зохион байгуулах, мэдээлэл хүргэх онцлог аргыг ашиглах

	ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	Дугаар: Ж-ТХХ-146-01
---	---	-------------------------

6. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ГОМДОЛ БАРАГДУУЛАХ, САНАЛ ХҮСЭЛТ ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ ЯВЦ

6.1 Үйл ажиллагаа

- 6.1.1 Оролцогч талуудын гомдол барагдуулах, санал хүсэлт шийдвэрлэх үйл явцыг Говь ХК-ийн Ж-ЗАА-28-03 дугаартай “Оролцогч талуудын өргөдөл, санал, гомдол хүлээн авах журам”-ын дагуу хэрэгжүүлнэ.

7. УДИРДЛАГЫН ХЯНАЛТ

7.1 Удирдлагын хяналт

- 7.1.1 Говь ХК нь өнөөдрийг хүртэл оролцогч талуудтай хамтран ажилласан хөтөлбөрийн үнэлгээ дүгнэлт дээрээ тулгуурлан Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө (Үйл ажиллагааны төлөвлөгөө) боловсруулсан. Уг төлөвлөгөө нь зорилтот бүлгүүд, тэдний онцлогт тохирсон хамтын ажиллагааны арга хэмжээг тодорхойлно.
- 7.1.2 Хавсралт 3-д 2023-2025 оны Үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн харуулав.
- 7.1.3 Компани, холбогдох оролцогч талуудын хэрэгцээ шаардлагыг хангаж, хүчин төгөлдөр байгаа эсэхийг баталгаажуулахын тулд 6 сар тутамд тус Үйл ажиллагааны төлөвлөгөөг тогтмол үнэлж дүгнэнэ. Үйл ажиллагааны төлөвлөгөөг Тогтвортой хөгжлийн хэлтсийн дарга хариуцах ба оролцогч талуудтай харилцах асуудал хариуцсан холбогдох менежерүүд биелэлтийг хангана.

7.2 Хэрэгжүүлэх хуваарь

- 7.2.1 Энэхүү удирдлагын төлөвлөгөөг 2 жил тутам эргэн харж, Говь ХК-ийн үйл ажиллагааны хэрэгцээ шаардлага, хувьсан өөрчлөгдөх нөхцөл байдлаас шалтгаалсан шаардлагатай өөрчлөлтүүдийг тусгаж шинэчилнэ.
- 7.2.2 Үйл ажиллагааны удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилтийг хариуцдаг Тогтвортой хөгжлийн хэлтсийн дарга тус удирдлагын төлөвлөгөөнд засвар оруулах үүрэг хүлээнэ.
- 7.2.3 Үйл ажиллагааны журмуудад томоохон өөрчлөлт орвол тус удирдлагын төлөвлөгөөнд “шаардлагын дагуу” өөрчлөлтийг тусган шинэчилнэ.

8. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

8.1 Хяналт шинжилгээний шаардлага

8.1.1 Говь ХК-ийн үйл ажиллагааны баримт бичгийн стандарт Ж-ТХХ-02-04 дугаартай “Баримтжуулсан мэдээллийн журам”-ын дагуу ОТХАУТ-ны гүйцэтгэлд хяналт тавина.

8.1.2 Хяналт шинжилгээгээр стандартын зөрчил илэрвэл зөрчлийг шалгаж, засаж залруулах арга хэмжээ авна.

8.2 Шалгуур үзүүлэлт

Код	Оролцогч талууд	Давтамж	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт
ОТХАУТ - 01	Үйлдвэрийн үйл ажиллагааны ойр орчим оршин суугч иргэд, байгууллагын ажилтнууд	Улирал, хагас жил	Тогтвортой хөгжлийн хэлтэс Хүний нөөцийн газар	1. Мэдээллийн самбар байршсан 2. Холбогдох журмуудыг танилцуулах олон нийтийн ажил 1-с доошгүй удаа зохион байгуулж, тэмдэглэл хөтөлсөн 3. Санал, гомдлын шийдвэрлэлтийн тайлан улирлаар гарсан
ОТХАУТ - 02	Бэлтгэн нийлүүлэгчид (малчин, хоршоо, компани)	Хагас жил, жилээр	Тогтвортой хөгжлийн хэлтэс, Худалдан авалтын хэлтэс Хөрөнгө бүртгэлийн алба	1. Бэлтгэн нийлүүлэгчид малчид, хоршоодын >80% нь үйл ажиллагаанд оролцсон 2. Хүний эрх, байгаль орчин хамгаалах сэдэвчилсэн сургалтын гарын авлага, тараах материалтай болсон 3. Санал, гомдол шийдвэрлэлтийн тайлан гарсан

GOBI
MONGOLIAN CASHMEREОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨДугаар:
Ж-ТХХ-146-01

ОТХАУТ - 03	Гэрээт гүйцэтгэгчид, тэдний ажилтнууд	Тухай бүр	Худалдан авалтын хэлтэс	<ol style="list-style-type: none">1. Гэрээт, гүйцэтгэгчийн менежментийн төлөвлөгөө батлагдаж, хэрэгжсэн2. Гэрээт ба гүйцэтгэгчийг хариуцсан ажилтан томилогдсон3. Зохистой хөдөлмөр эрхлэлт ба байгаль орчны шаардлага гэрээнд заалтаар орж, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт болсон4. Санал, гомдол шийдвэрлэлтийн тайлан гарсан
ОТХАУТ - 04	Үйлчлүүлэгчид, хэрэглэгчид	Жилээр	Дотоод борлуулалтын газар	<ol style="list-style-type: none">1. Нээлттэй хаалганы өдөр зохион байгуулагдсан, тайлан гарсан2. Дэлгүүрүүдэд үйлчлүүлэгчдийн мэдээллийн самбар байршуулсан3. Санал, гомдол шийдвэрлэлтийн тайлан гарсан
ОТХАУТ - 05	Эмзэг бүлэг	Тухай бүр	Гадаад болон дотоод маркетинг, Контент хөгжүүлэлтийн хэлтэс, Тогтвортой хөгжлийн хэлтэс, Хүний нөөцийн газар	<ol style="list-style-type: none">1. Тэрбум мод зэрэг нөлөөллийн ажлын санаачилгад эмзэг бүлгийн төлөөллийг хамруулах тухайлсан шаардлага оруулсан2. Тусгай зориулалтын сургууль, цэцэрлэгтэй хамтарч ажиллах судалгаа хийсэн3. Брэндингийн мэдээлэлд Брайль үсэг ашиглаж, туршилт хийсэн

	<p style="text-align: center;">ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ</p>	<p style="text-align: center;">Дугаар: Ж-ТХХ-146-01</p>
---	---	---

9. СУРГАЛТ

9.1 Сургалтын шаардлага

- 9.1.1 Бүх шаардлагатай сургалтуудыг баримжаа олгох сургалтын (ерөнхий мэдлэг олгох) бүрдэл хэсэг болгон оруулах ба шаардлагатай бол ажлын байрны сургалт явуулна.
- 9.1.2 Говь ХК-ийн үндсэн болон гэрээт байгууллагын ажилчид олон соёлын нэгдмэл харилцаанд орох шаардлага гардаг ба чиг баримжаа олгох стандарт сургалтын хөтөлбөрт хүний эрхийн сэдвийг оруулж, ОТХАУТ болон Гомдол барагдуулах, санал хүсэлт шийдвэрлэх журмыг хэрэгжүүлэх талаар холбогдох оролцогч талуудад сургалт зохион байгуулна.

10. АУДИТ БА ТАЙЛАГНАЛ

10.1 Аудит

- 10.1.1 Энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтэд жил бүр Дотоод аудитын хэлтсийн зүгээс хяналт, аудит хийнэ.
- 10.1.2 Гэрээт байгууллага ГОВЬ ХК-тай гэрээ байгуулахын өмнө нийцлийн үнэлгээ хийлгэх (Гэрээт гүйцэтгэгчийн удирдлагын журамд заасан) ба үүнээс хойш Гэрээт байгууллагын удирдлагын төлөвлөгөөнд зааснаар жил бүр шалгуулна.
- 10.1.3 Энэ төлөвлөгөөний хэрэгжилтийг зээлдүүлэгчдийн/хөрөнгө оруулагчийн хугацаат аудитаар үнэлж, тайлагнана.

10.2 Тайлагнал

- 10.2.1 Энэ төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг Тогтвортой хөгжлийг хэлтсийн дарга удирдаж бусад холбогдох хэлтэстэй нэгжтэй хамтран боловсруулж Гүйцэтгэх удирдлагад тайлагнаж, компанийн жилийн үйл ажиллагааны тайланд орж олон нийтэд тайлагнана.

	<p style="text-align: center;">ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ</p>	<p style="text-align: center;">Дугаар: Ж-ТХХ-146-01</p>
---	---	---

11. ХАВСРАЛТ 1

ГОВЬ ХК-ийн Оролцогч талуудын хамтын ажиллагааны удирдамж

ГОВЬ ХК-ийн Оролцогч талуудын хамтын ажиллагааны удирдамж нь ГОВЬ ХК-ийн оролцогч талуудынхаа ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, тэдгээрийн зохистой тэнцвэрийг хадгалсан ажлуудыг хэрэгжүүлэн хамтран ажиллах харилцаа бий болгож, хөгжүүлэхэд чиглэнэ. Тус удирдамжийг Оролцогч талуудын хамтын ажиллагааны менежментийн төлөвлөгөөнд тулгуурлаж боловсруулсан ба оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах зарчим, арга барил, үйл явцыг тусгаснаас гадна бүх уулзалт, хамтын ажиллагааг баримтжуулж бүртгэх маягтуудыг оруулсан.

Энэхүү удирдамж нь Оролцогч талуудын хамтын ажиллагааны удирдлагын төлөвлөгөөний салшгүй нэг хэсэг бөгөөд бусад холбогдох баримт бичгийн дагуу 1 жил тутам сайжруулан шинэчилнэ.

Оролцогч талуудын хамтын ажиллагааны удирдлагын систем нь хэрэгжилтийн шатанд аливаа хамтын ажиллагааг бүртгэх, тэмдэглэх, хянах, тайлагнахаас бүрдэнэ. Үүнд:

1. Уулзалт, хамтын ажиллагааны бүртгэлийн маягт дээр бүртгэх (маягтыг харна уу)
 - Уулзалт, хамтын ажиллагааны огноо, цаг, байршил, төрөл
 - Оролцогч
 - Уулзалт, хамтын ажиллагааны дэлгэрэнгүй тэмдэглэл, уулзалтын мөрөөр авах арга хэмжээ, хэлэлцсэн сэдэв, уулзалтын мөрөөр авах арга хэмжээ зэргийг баримтжуулах зураг, баримт бичиг,
 - ГОВЬ ХК-ийн ажилтан, оролцогчдын гарын үсэг
2. Уулзалт, хамтын ажиллагааны бүртгэлд бүртгүүлэх
3. Уулзалтын мөрөөр авах арга хэмжээний гүйцэтгэлийн статусыг бүртгэх
4. Улирал тутам тайлагнах

Тайланд дараах зүйлсийг багтаана. Үүнд:

- Түвшин бүрт хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, арга хэмжээ, оролцогчдын тоо
- Уулзалтын мөрөөр авах арга хэмжээний статус
- Уулзалт, хамтын ажиллагаа, арга хэмжээний өмнөх болон дараах оролцогч талуудын хандлага



ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Дугаар:
Ж-ТХХ-146-01

Оролцогч талуудын хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн /Тогтвортой хөгжлийн менежер/ удирдлага, бусад холбогдох хэлтэс, багийн гишүүдэд мэдээллийг цаг тухайд нь хүргэнэ.

Уулзалт, хамтын ажиллагааны бүртгэлийн маягт

Баримт бичгийн төрөл: Журам – Тогтвортой хөгжлийн хэлтэс

Баталсан огноо:

Баримт бичгийн хувилбарын дугаар:

А. Уулзалтын огноо, цаг:			
Б. Уулзалтын байршил:			
В. Уулзалтын сэдэв: уулзалт <input type="checkbox"/> хүсэлт <input type="checkbox"/> гомдол <input type="checkbox"/> санаачилга <input type="checkbox"/> санал <input type="checkbox"/> бусад <input type="checkbox"/>			
Г. Оролцогчдын мэдээлэл:			
д/д	Оролцогчийн овог, нэр	Оролцогчийн тодорхойлолт	Холбоо барих мэдээлэл

Д. Уулзалтын тэмдэглэл: Дэлгэрэнгүй мэдээлэл оруулна

	<p style="text-align: center;">ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ</p>	<p style="text-align: right;">Дугаар: Ж-ТХХ-146-01</p>
---	---	--

--

Е. Уулзалтын мөрөөр авах арга хэмжээ:

д/д	Хийх ажил	Хугацаа	Хариуцах хүн	Биелэлт

Ё. Уулзалттай холбоотой баримт, зураг бусад биет мэдээллийг жагсаалт хийж, хавсаргана.

д/д	Биет мэдээллийн (баримт, файл, зураг гм) нэр	Товч агуулга

Тэмдэглэл хөтөлсөн (компанийн ажилтан овог, нэр, гарын үсэг):

Тэмдэглэлтэй танилцсан (оролцогч талын гол төлөөллийн овог, нэр, гарын үсэг):

	<p style="text-align: center;">ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ</p>	<p style="text-align: center;">Дугаар: Ж-ТХХ-146-01</p>
---	---	---

12. ХАВСРАЛТ 2

ҮНДСЭН ОРОЛЦОГЧ ТАЛУУД

Бэлтгэн нийлүүлэгчид

ГОВЬ ХК нь үйлдвэрийн үндсэн түүхий эд ноолуураа Хөвсгөл, Увс, Ховд, Баянхонгор, Сүхбаатар, Хэнтий, Дорнод, Завхан аймгуудын компани, хоршоо, малчдаас бэлтгэн (Хүснэгт В1) нийлүүлдэг.

Хүснэгт В1. Бэлтгэн нийлүүлэгчид болон бусад оролцогч талууд

Бэлтгэн нийлүүлэгчдийн бүлэг	Нэрс
Малчид	Хоршоод
	Малчид
	Гэрээт компаниуд
Үйлдвэрлэл	Мэргэжлийн сургуулиуд /ШУТИС, ХААИС, МСТК/
	Мэргэжлийн холбоод /МННХ гэх мэт
	Төрийн байгууллагууд /ХХААХҮЯ, УСУГ гэх мэт/
	Баталгаажуулалтын байгууллагууд, итгэмжлэгдсэн лабораториуд
Гадаад борлуулалт	Туслах гүйцэтгэгч гэрээт байгууллагууд
	Гадаад хэрэглэгч
	Хамтрагч байгууллагууд
	Гэрээт гүйцэтгэгч байгууллагууд
	Зөвлөх байгууллага

	<p style="text-align: center;">ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ</p>	<p style="text-align: center;">Дугаар: Ж-ТХХ-146-01</p>
---	---	---

	Зөвлөх хувь хүн
Дотоод борлуулалт	Монгол хэрэглэгч
	Жуулчид
	Гэрээт гүйцэтгэгч нар /модель, хамтрагч байгууллагууд/
	Төрийн байгууллагууд /төрийн яамдууд, элчин сайдын яам/
	Жуулчны компаниуд
Экспортын борлуулалт	ODM харилцагчид
Хэвлэл мэдээлэл	Сайт
	Телевиз
Ханган нийлүүлэгч	Гадаад & дотоод ханган нийлүүлэгч (туслах бараа материал нийлүүлэгч)
	Гадаад & дотоод ханган нийлүүлэгч (тоног төхөөрөмж нийлүүлэгч)
	Гадаад & дотоод гэрээт гүйцэтгэгч (ажил үйлчилгээ, загвар өмсөгч, драп боловсруулах үйлдвэр гэх мэт)
	Тээвэр ложистикийн компаниуд
Гэрээт байгууллага	Ажил үйлчилгээ худалдан авах



ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Дугаар:
Ж-ТХХ-146-01

	Бараа бүтээгдэхүүн нийлүүлэх
	Барилга байгууламжийн засвар үйлчилгээ
	Химийн бодисын тээвэрлэлт
	Мэргэжлийн эрх бүхий байгууллагууд /Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ, Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг/
Иргэн, ААНБ-ууд	Ойр орчмын оршин суугчид
	Ойр орчимд Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж буй ААНБ-ууд
	Жижиг дунд бизнес эрхлэгчид
Хүний нөөц	ТУЗ
	Удирдлага
	Ажилтан
	Хөрөнгө оруулагчид

	<p style="text-align: center;">ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ</p>	<p style="text-align: center;">Дугаар: Ж-ТХХ-146-01</p>
---	---	---

Дүүрэг, хорооны эрх бүхий байгууллага, газрууд

ГОВЬ ХК-ийн үйл ажиллагаа явуулдаг хороо, дүүргийн эрх бүхий байгууллага, газруудын оролцогч талуудыг Хүснэгт В2-т үзүүлэв.

Хүснэгт В2: Эрх бүхий байгууллага, газрууд: Дүүрэг, хорооны түвшинд

Төрийн байгууллага	Компанийн сонирхол/харилцаа
ИТХ, ИТХ-н дарга	Нийгэм, эдийн засгийн хөгжил
Засаг дарга, засаг даргын орлогч	Нийгэм, эдийн засгийн хөгжил
Засаг даргын тамгын газар	Нийгэм, эдийн засгийн хөгжил
Газрын алба	Газар ашиглалт, гэрээ, тайлан
Байгаль орчны хэлтэс	Байгаль орчны менежмент, бохирдлоос урьдчилан сэргийлэх, химийн бодис зөвшөөрөл
Цагдаагийн хэлтэс/ Тээврийн цагдаагийн алба / Экологийн цагдаагийн алба	Замын хөдөлгөөний аюулгүй байдал, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгэм, байгаль орчны аюулгүй байдал
Эрүүл мэндийн төв, хэлтэс	Үйл ажиллагааны ойролцоо оршин суугч иргэдийн эрүүл мэнд, халдварт ба халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн үзлэг
Хөдөлмөр, нийгмийн халамжийн хэлтэс	Хороо, дүүргийн хөдөлмөр эрхлэлт, эмзэг бүлгийн хүмүүсийг дэмжих, мэдээлэл солилцох
Татварын хэлтэс	Татвар төлөлт, мэдээлэл солилцох
Онцгой байдлын хэлтэс	Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх, төлөвлөгөө батлуулах, галын болон бусад сургалт, сургуулилалт
Хяналтын байцаагчид	Хөдөлмөр, эрүүл ахуй, байгаль орчны хууль тогтоомжийн нийцлийг хангах чиглэлээр

	<p style="text-align: center;">ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ</p>	<p style="text-align: center;">Дугаар: Ж-ТХХ-146-01</p>
---	---	---

Засгийн газрын яам, агентлагууд

ГОВЬ ХК нь үйл ажиллагааныхаа хүрээнд Монгол улсын засгийн газрын яам, агентлагуудын оролцогч талуудтай (Хүснэгт Б2) хамтарч ажилладаг.

ХүснэгтБ2. Засгийн газрын агентлаг, яамдын оролцогч талууд

Захиргаа/удирдах байгууллага	Компанийн сонирхол/ харилцаа
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Салбарын бодлого стратеги боловсруулахад хувь нэмрээ оруулах, түүхий эд нийлүүлэгчдийг дэмжих, гадаад зах зээлд гарах харилцаа зохицуулах
Сангийн яам	Татвар, гаалийн татвар,
Хууль зүй, дотоод хэргийн яам	Зөвшөөрөл, нийцэл
Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, усны зөвшөөрөл, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, биологийн олон янз байдлыг дэмжих, Тэрбум мод хөтөлбөрт оролцох
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа ба нөхцөл, нийгмийн бодлогын чиглэлээр
Боловсрол, шинжлэх ухааны яам	Туршилт судалгаа, инноваци хөгжил, сургууль цэцэрлэгийг дэмжих, МСҮТ-тэй хамтарч мэргэжилтэн ур чадвар бэлтгэх
Цахим хөгжил, харилцаа холбооны яам	Цахим аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдал
Барилга, хот байгуулалтын яам	Газрын харилцаа, кадастр, дэд бүтэц
Соёлын яам	Соёлын биет ба биет бус өвийг хамгаалах чиглэлээр

	<p>ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ</p>	<p>Дугаар: Ж-ТХХ-146-01</p>
---	---	---------------------------------

Эдийн засаг, хөгжлийн яам	Тогтвортой хөгжлийн зорилгыг гүйцэтгэлийг тайлагнах чиглэлээр
Нийслэлийн зам хөгжлийн төв	Авто замын ашиглалтаар
Санхүүгийн зохицуулах хороо	Компанийн засаглалтай холбоотой асуудлаар эрх зүйн нийцлийг хангах
Стандарт, хэмжил зүйн газар	Хэмжих багаж, хэрэгслийн тохируулга, баталгаажуулалт, тохирлын гэрчилгээ, сорьцын туршилт, итгэмжлэл
Гаалийн ерөнхий газар	Гаалийн бүрдүүлэлт, экспорт, импорт
Монголын хөрөнгийн бирж	Үнэт цаастай холбоотой асуудлаар дүрэм журмын нийцэл, мэдээллийн ил тод байдлыг хангах
Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв	Хувьцааны бүртгэл, ногдол ашиг тараалт

	<p style="text-align: center;">ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ</p>	<p style="text-align: center;">Дугаар: Ж-ТХХ-146-01</p>
---	---	---

Үндэсний болон олон улсын ТББ, хандивлагч, бусад байгууллагууд

Хүснэгт В4: Үндэсний болон олон улсын ТББ, хандивлагч, бусад байгууллагуудын товч мэдээлэл.

Байгууллагын чиглэл	Нэрс
Мэргэжлийн холбоо	Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим
	Ажил олгогч эздийн холбоо
	Монголын ноос, ноолуурын холбоо
	Монголын бизнесийн зөвлөл
	Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо
Иргэний нийгмийн байгууллага	Бэлчээр ашиглагчдын холбоо
	Улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэг
Мэргэжлийн сургуулиуд	Шинжлэх ухаан, технологийн их сургууль (ШУТИС)
	Хөдөө аж ахуйн их сургууль (ХААИС)
	Монгол-Солонгосын Политехникийн Коллеж
	Сургалтын байгууллагууд /Төр болон бизнесийн/
Банк санхүүгийн байгууллагууд	Хаан банк

	<p align="center">ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ</p>	<p align="center">Дугаар: Ж-ТХХ-146-01</p>
---	--	--

	Голомт банк
	Хас банк
	Ариг банк
	Монгол улсын хөгжлийн банк
	Олон улсын хөрөнгө оруулалтын банк
	Европын Сэргээн Босголт Хөгжлийн банк
	Азийн хөгжлийн банк
Олон улсын байгууллагууд	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр
	Монголын Тогтвортой ноолуурын платформ
	ОЕКО-ТЕКС байгууллага
	SGS ISO стандартууд
	МННХ
	Бэлчээр ашиглалтын холбоо
	МУХАҮТ
	SFA



ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Дугаар:
Ж-ТХХ-146-01

Даатгалын компаниуд	Миг даатгал
	Монре даатгал
Бүрдүүлэлтийн компани	SCC
	Zangia.mn
	Worki

	ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	Дугаар: Ж-ТХХ-146-01
---	---	-------------------------

13. ХАВСРАЛТ 3

ГОВЬ ХК-ийн Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө (2023-2025 он)

Код	Оролцогч талууд	Зорилго	Харилцаа, хамтын ажиллагаа	Давтамж	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт
ОТХАУ Т – 01	Үйлдвэрийн үйл ажиллагааны ойр орчим оршин суугч иргэд, байгууллагын ажилтнууд	Үйл ажиллагааны тухай мэдээлэл хүргэх, санал гомдол хүлээн авч оролцогч талуудын итгэлцлийг бүрдүүлэх	Харьяалах хорооны удирдлагын ордонд Говь ХК-н Мэдээллийн самбар байршуулж, дараах мэдээллийг түгээх: <ul style="list-style-type: none"> • Үйл ажиллагааны ерөнхий мэдээлэл (худалдан авалт, хөдөлмөр эрхлэлт, төсөл хөтөлбөр) • Нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдлын журам танилцуулах • Санал, гомдол хүлээж авах, барагдуулах механизмыг танилцуулах 	Улирал, хагас жил	Тогтвортой хөгжлийн хэлтэс Хүний нөөцийн газар	1. Мэдээллийн самбар байршсан 2. Холбогдох журмуудыг танилцуулах олон нийтийн ажил 1-с доошгүй удаа зохион байгуулж, тэмдэглэл хөтөлсөн 3. Санал, гомдлын шийдвэрлэлтийн тайлан улирлаар гарсан

<p>ОТХАУ Т - 02</p>	<p>Бэлтгэн нийлүүлэгч ид (малчин, хоршоо, компани)</p>	<p>Түүхий эдийн чанарын шаардлагаас гадна, хүний эрх, байгаль орчин хамгаалах тухай мэдлэг олгож бүтээгдэхүүний хүн ба байгаль орчинд ээлтэй, органик нэр хүндийг баталгаажуулах</p>	<ul style="list-style-type: none"> • Говь ХК-н үйл ажиллагаатай танилцах аялал зохион байгуулах • Хүний эрх, байгаль орчин хамгаалах чиглэлээр сургалт сурталчилгаа зохион байгуулах • Санал, гомдол хүлээж авах, барагдуулах механизмыг танилцуулах 	<p>Хагас жил, жилээр</p>	<p>Тогтвортой хөгжлийн хэлтэс, Худалдан авалтын хэлтэс</p> <p>Хөрөнгө бүртгэлийн алба</p>	<p>4. Бэлтгэн нийлүүлэгчид малчид, хоршоодын >80% нь үйл ажиллагаанд оролцсон</p> <p>5. Хүний эрх, байгаль орчин хамгаалах сэдэвчилсэн сургалтын гарын авлага, тараах материалтай болсон</p> <p>6. Санал, гомдол шийдвэрлэлтийн тайлан гарсан</p>
<p>ОТХАУ Т - 03</p>	<p>Гэрээт гүйцэтгэгчи д, тэдний ажилтнууд</p>	<p>Зохистой хөдөлмөр эрхлэлтийн ойлголтыг төлөвшүүлж, хүний эрхийг хүндэтгэхэд хамтын чармайлт гаргах</p>	<ul style="list-style-type: none"> • Гэрээт, гүйцэтгэгчийн менежментийн төлөвлөгөөг хэлэлцэж, баталгаажуулах, зохистой хөдөлмөр эрхлэлт ба байгаль орчны шаардлагуудыг гэрээнд оруулах, мөрдүүлэх • Санал, гомдол хүлээж авах, барагдуулах механизмыг танилцуулах 	<p>Тухай бүр</p>	<p>Худалдан авалтын хэлтэс</p>	<p>7. Гэрээт, гүйцэтгэгчийн менежментийн төлөвлөгөө батлагдаж, хэрэгжсэн</p> <p>8. Гэрээт ба гүйцэтгэгчийг хариуцсан ажилтан томилогдсон</p> <p>9. Зохистой хөдөлмөр эрхлэлт ба байгаль орчны шаардлага гэрээнд заалтаар орж, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт болсон</p> <p>10. Санал, гомдол шийдвэрлэлтийн тайлан гарсан</p>

<p>ОТХАУ Т - 04</p>	<p>Үйлчлүүлэгчид, хэрэглэгчид</p>	<p>Зохистой хэрэглээг сурталчлан таниулах, итгэлцлийг бүрдүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> • Нээлттэй хаалганы өдөр зохион байгуулах • Дэлгүүрүүдэд үйлчлүүлэгчийн мэдээллийн самбар ажиллуулах • Санал, гомдол хүлээж авах, барагдуулах механизмыг танилцуулах 	<p>Жилээр</p>	<p>Дотоод борлуулалтын газар</p>	<p>11. Нээлттэй хаалганы өдөр зохион байгуулагдсан, тайлан гарсан</p> <p>12. Дэлгүүрүүдэд үйлчлүүлэгчдийн мэдээллийн самбар байршуулсан</p> <p>13. Санал, гомдол шийдвэрлэлтийн тайлан гарсан</p>
<p>ОТХАУ Т - 05</p>	<p>Эмзэг бүлэг</p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бусад нийгмийн эмзэг бүлэгт нийгэмших зан үйлд дэмжлэг болох</p>	<ul style="list-style-type: none"> • Нийгмийн нөлөөллийн ажлууд зохион байгуулах • Тусгай зориулалтын сургууль, цэцэрлэгтэй хамтарч ажиллах • Брэндингийн мэдээлэлд Брайль үсэг ашиглах боломж эрэлхийлэх 	<p>Тухай бүр</p>	<p>Гадаад болон дотоод маркетинг, Контент хөгжүүлэлтийн хэлтэс, Тогтвортой хөгжлийн хэлтэс, Хүний нөөцийн газар, Хүний нөөцийн газар</p>	<p>14. Тэрбум мод зэрэг нөлөөллийн ажлын санаачилгад эмзэг бүлгийн төлөөллийг хамруулах тухайлсан шаардлага оруулсан</p> <p>15. Тусгай зориулалтын сургууль, цэцэрлэгтэй хамтарч ажиллах судалгаа хийсэн</p> <p>16. Брэндингийн мэдээлэлд Брайль үсэг ашиглаж, туршилт хийсэн</p>

20.23 он 11 сар 20 өдөр

Дугаар 36

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журмыг батлах тухай

Говь ХК-ийн засаглалын тогтолцоог бэхжүүлэх, компанийн хувьцаа эзэмшигчдийн эрх, ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журмыг батлах тухай асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13, Компанийн дүрмийн 6.2.7.11 дүгээр заалтыг удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

Нэг. Говь ХК-ийн “Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам”-ыг Хавсралт-1 ёсоор баталсугай.

Хоёр. Энэхүү журмыг баталсантай холбоотой 2021 оны 09-р сарын 27-ны өдрийн №25 тоот тогтоолоор баталсан “Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журам”-ыг хүчингүйд тооцсугай.

Гурав. Батлагдсан журмыг үйл ажиллагаандаа мөрдөн, хэрэгжилтийг хангаж ажиллахыг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал /Ц.Баатарсайхан/, Хуулийн хэлтсийн дарга /Ц.Цасчихэр/, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Сэлэнгэ/ нарт үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ГЭРЭЛМАА

GOBI
MONGOLIAN CASHMERE

СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ
ЖУРАМ





ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ
ЗӨВЛӨЛ
Дугаар:
Ж-ТУЗ-147-01

ТТН2998-1-2076357

БАРИМТ БИЧГИЙН НЭР:

ГОВЬ ХК-ИЙН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЖУРАМ

БАРИМТ БИЧГИЙН ХАРИУЦАГЧ	ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА		
БАРИМТ БИЧГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ	КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД, ТУЗ-ИЙН ГИШҮҮД, ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУД, НИЙТ АЖИЛТНУУД		
БАТЛАГДСАН ОГНОО	2023.11.20		
БАРИМТ БИЧГИЙН НУУЦЛАЛЫН ЗЭРЭГЛЭЛ	НЭЭЛТТЭЙ	БАРИМТ БИЧГИЙН ТҮВШИН	T2

	АЛБАН ТУШААЛ	НЭР	ГАРЫН ҮСЭГ
БАТАЛСАН:	ТУЗ-ИЙН ДАРГА	Д.ГЭРЭЛМАА	
ХЯНАСАН:	ТУЗ-ИЙН ГИШҮҮН	Ц.БААТАРСАЙХАН	
	ТУЗ-ИЙН ГИШҮҮН	Б.АМАРСАЙХАН	
	ТУЗ-ИЙН ГИШҮҮН	Ц.ОРГИЛБОЛД	
	ТУЗ-ИЙН ГИШҮҮН	А.ЖАРГАЛМАА	
	ТУЗ-ИЙН ГИШҮҮН	Д.ХУЛАН	
	ТУЗ-ИЙН ГИШҮҮН	Д.ХҮРЭЛБААТАР	
	ХХ-ИЙН ДАРГА	Ц.ЦАСЧИХЭР	
	ТХХ-ИЙН ДАРГА	Э.ИВГЭЭЛ	
БОЛОВСРУУЛСАН:	ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	М.СЭЛЭНГЭ	

Улаанбаатар хот

2023 он

	СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЖУРАМ	Дугаар: Ж-ТУЗ-147-01
---	--	-------------------------

Баримт бичгийн өөрчлөлтийн бүртгэл			
Хувилбарын дугаар	Хүчин төгөлдөр болсон огноо	Өөрчлөлт оруулж, боловсруулсан албан тушаалтан	Өөрчлөлтийн утга (баримт бичигт ямар өөрчлөлт орсныг товч тайлбарлана)
01	2023.11.20	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ	Баримт бичгийн анхны хувилбар.

Баримт бичгийн төлөв		
Эх хувь	Албан хэрэгцээний хувь	Хүчингүй хувь
<div style="border: 1px solid red; padding: 5px; width: fit-content; margin: auto;"> <p style="text-align: center; color: red;">ГОВЬ ХК ЭХ ХУВЬ</p> <p style="font-size: small;">Гарын үсэг: <i>Ариунзүрэг</i> 2023 он 11 сар 22 өдөр</p> </div>		

ИШ ТАТСАН БАРИМТ БИЧГҮҮД		
№	Баримт бичгийн нэр	Бүртгэлийн дугаар
1	"Компанийн засаглалын кодекс"	Санхүүгийн зохицуулах хорооны 2022.03.23-ны №145 тогтоол
2	"Компанийн тухай хууль"	УИХ-ын 2011.10.06-ны хурлаар батлагдсан, сүүлд 2020.04.24-нд нэмэлт өөрчлөлт орсон.
3	"Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"	УИХ-ын 2013.05.24-ний хурлаар батлагдсан, сүүлд 2022.06.17-нд нэмэлт өөрчлөлт орсон.
4	"Говь ХК-ийн дүрэм"	Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2020.04.24-ний №02 тогтоол
5	Говь ХК-ийн "Засаглалын бодлого"	Б-ТУЗ-14-01
6	Говь ХК-ийн "Ёс зүйн код"	Д-ТХХ-01-02
7	Говь ХК-ийн "Эрсдэл, аудитын хорооны үйл ажиллагааны журам"	Ж-ТУЗ-03-01
8	Говь ХК-ийн "Олон нийтэд хүргэх мэдээллийн журам"	Ж-ТУЗ-104-02

АГУУЛГА

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	4
1.1 Зорилго	4
1.2 Хамрах хүрээ	4
1.3 Нэр томъёоны тайлбар	4
1.4 Үүрэг, хариуцлагын матриц.....	5
2. НЭГДМЭЛ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ	7
2.1 Нэгдмэл сонирхолтой этгээд	7
2.2 Нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдүүлэг гаргах	7
2.3 Нэгдмэл сонирхолтой этгээдийг бүртгэх.....	8
3. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ	8
3.1 Сонирхлын зөрчил бүхий этгээд.....	8
3.2 Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тавигдах шаардлага	9
3.3 Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх	9
3.4 Сонирхлын зөрчилтэй хэлцлийг бүртгэх.....	11
3.5 Сонирхлын зөрчилтэй хэлцлийг тайлагнах.....	11
4. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ	12
4.1 Хувьцаа эзэмшигчдийн эрх, үүрэг	12
4.2 ТУЗ-ийн эрх, үүрэг.....	12
4.3 ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эрх, үүрэг	13
4.4 Гүйцэтгэх захирлын эрх, үүрэг.....	13
4.5 Хуулийн хэлтсийн даргын эрх, үүрэг	14
4.6 ЭБАТ-уудын эрх, үүрэг.....	14
5. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА	15
5.1 Хяналт тавих	15
5.2 Хариуцлага хүлээлгэх	15
6. БУСАД	15
6.1 Бусад зүйл	15
7. ХАВСРАЛТ	16
Хавсралт №1. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх процесс зураглал.....	16
Хавсралт №2. ЭБАТ-ны нэгдмэл сонирхлын мэдүүлэг	17
Хавсралт №3. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдийг бүртгэх хуудас.....	20
Хавсралт №4. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг бүртгэх хуудас.....	20

	СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЖУРАМ	Дугаар: Ж-ТУЗ-147-01
---	--	-------------------------

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Зорилго

1.1.1 Энэхүү журмын зорилго нь Говь ХК (цаашид “Компани” гэх) болон компанийн хувьцаа эзэмшигчдийн эрх, ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2 Хамрах хүрээ

1.2.1 Энэхүү журам нь олон нийтэд нээлттэй байх бөгөөд Компанийн хувьцаа эзэмшигчид, ЭБАТ-ууд болон нийт ажилтнуудад хамаарна.

1.3 Нэр томъёоны тайлбар

1.3.1 Уг журмын хүрээнд дараах нэр томъёог ашиглана.

- 1.3.1.1 **Эрх бүхий албан тушаалтан:** Компанийн ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, дэд захирлууд, газрын захирлууд, хуулийн зөвлөх, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог Компанийн дүрмээр тодорхойлсон удирдах албан тушаалтнууд;
- 1.3.1.2 **Ашиг сонирхлын зөрчил:** Компанийн ЭБАТ хууль болон гэрээгээр олгогдсон эрхээ хэрэгжүүлэх явцад түүний хувийн ашиг сонирхол Компанийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ үнэнч, шударгаар хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж болохуйц нөхцөл байдал;
- 1.3.1.3 **Компанийн ашиг сонирхол:** Компанийн эрхэмлэх үнэт зүйлс, баримтлах зарчим, стратеги, менежментийн бодлого, тушаал, шийдвэр, компанид мөрдөгдөж байгаа бүхий л дүрэм, журам, заавар, аргачлалд нийцсэн эдийн болон эдийн бус ашиг сонирхол;
- 1.3.1.4 **Хувийн ашиг сонирхол:** Ажилтан албан үүргээ гүйцэтгэх явцад өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхол;
- 1.3.1.5 **Сонирхлын зөрчил бүхий этгээд:** Компанийн тухай хуулийн 89.1-д заасан этгээд буюу Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн ЭБАТ, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай хэлцэл хийх этгээд;

	СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЖУРАМ	Дугаар: Ж-ТУЗ-147-01
---	--	-------------------------

- 1.3.1.6 **Нэгдмэл сонирхолтой этгээд:** Компанийн тухай хуулийн 89.2-д заасан этгээд буюу Компанийн ЭБАТ-ны эцэг, эх, төрсөн ах, эгч дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, болон тэдэнтэй ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээд;
- 1.3.1.7 **Нэгдмэл сонирхлын мэдүүлэг:** Ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй этгээдүүд, тэдгээрийн талаар Компанийн ЭБАТ-ны гаргаж өгсөн мэдээлэл;
- 1.3.1.8 **Сонирхлын зөрчилтэй хэлцэл:** Сонирхлын зөрчил бүхий этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааны хяналтын багцыг эзэмшиж байгаа компанитай хийж буй гэрээ, хэлцэл;
- 1.3.1.9 **Хувьцааны хяналтын багц:** Компанийн гаргасан энгийн хувьцааны 1/3 (гуравны нэг) буюу түүнээс дээш хэмжээний хувьцаа;

1.3.2 **Товчлол:** Баримт бичигт дор дурдсан товчилсон үгийг ашиглаж болно.

Хүснэгт 1 Товчилсон үгийн тайлбар

№	Товчилсон үгийн тайлбар	Товчилсон үг
1	Хувьцаа эзэмшигчдийн хурал	ХЭХ
2	Төлөөлөн удирдах зөвлөл	ТУЗ
3	Эрсдэл, аудитын хороо	ЭАХ
4	Эрх бүхий албан тушаалтан	ЭБАТ

1.4 Үүрэг, хариуцлагын матриц

Хүснэгт 1 Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх үүрэг хариуцлагын матриц

Процесс \ Албан тушаал	ХЭХ	ТУЗ	ЭАХ	Гүйцэтгэх захирал	ЭБАТ	Хуулийн хэлтсийн дарга	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
	/Г-гүйцэтгэх, Х-хариуцах, З-зөвлөлдөн хамтран ажиллах, М-мэдээлэл авах/						
Нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдүүлэг гаргах, тухай бүр шинэчлэх		М			ГХ	З	З

Нэгдмэл сонирхолтой этгээдийг бүртгэх, жагсаалт гаргах, тухай бүр шинэчлэх	М	М		М		З	ГХ
Нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээллийг хүлээн авах, гэрээ хэлцэл хийхэд хяналт тавих		М		З	З	ГХ	З
Сонирхлын зөрчил үүсвэл мэдэгдэх, хэлцлийг шийдвэрлэхэд санал өгөхгүй байх		Г		Г	ГХ	З	З
Сонирхлын зөрчилтэй хэлцлийг ТУЗ-өөр шийдвэрлэх	М	ГХ		З	М	З	З
Сонирхлын зөрчилтэй хэлцлийг ХЭХ-аар шийдвэрлэх	ГХ	З				З	З
Сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих		З	ГХ				З
Сонирхлын зөрчилтэй хэлцлийг бүртгэх		М		З	З	Г	ГХ
Сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар олон нийтэд мэдээлэх	М	М		З	З	З	ГХ
Сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар ХЭХ-д тайлагнах	М	З	ГХ				З

- 1.4.1 Энэхүү журмыг Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекс, Компанийн дүрэм болон зохицуулах байгууллагаас гаргасан бусад хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд Компанийн ТУЗ-өөс баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.
- 1.4.2 Уг журмыг ТУЗ-ийн хурлаар баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөрт тооцох бөгөөд журамд нэмэлт өөрчлөлт оруулах эрхийг ТУЗ эдэлнэ.
- 1.4.3 ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад ЭБАТ-ууд, Хуулийн хэлтсийн дарга, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нар нь үйл ажиллагаандаа уг журмын хэрэгжилтийг ханган ажиллана.

2. НЭГДМЭЛ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ

2.1 Нэгдмэл сонирхолтой этгээд

- 2.1.1 Дараах ЭБАТ-ууд нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргаж өгөх үүрэгтэй. Үүнд:
- 2.1.1.1 ТУЗ-ийн гишүүд;
 - 2.1.1.2 Гүйцэтгэх захирал;
 - 2.1.1.3 Менежмент багийн удирдлагууд;
- 2.1.2 Дор дурдсан этгээдийг компанийн ЭБАТ-тай нэгдмэл сонирхолтой этгээд гэж үзнэ. Үүнд:
- 2.1.2.1 Тэдгээрийн эхнэр, нөхөр, тэдэнтэй хамт амьдарч байгаа гэр бүлийн бусад гишүүн;
 - 2.1.2.2 Тэдгээрийн эцэг, эх, хүүхэд, ач, зээ болон ах, эгч, дүү;
 - 2.1.2.3 Тэдгээр нь өөрсдийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшдэг компанитай хийгдэж байгаа хэлцлийн үр дүнгээс шууд болон шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа тохиолдолд уг гэрээнд оролцогч талууд;
 - 2.1.2.4 Тодорхой гэрээний үндсэн дээр хамтран Компанийн удирдлагын шийдвэрийг тодорхойлох боломж бүхий компани болон хүн /бүлэг хүмүүс/;
 - 2.1.2.5 Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь хувьцааны хяналтын багцыг нь эзэмшдэг болон эрх бүхий албан тушаалд ажилладаг компани, уг компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогч компани болон тэдгээрийн хувьцааны хяналтын багцыг эзэмшигч болон ЭБАТ;
 - 2.1.2.6 Уг этгээд ажил олгогч бол түүний ажилтан;

2.2 Нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдүүлэг гаргах

- 2.2.1 ЭБАТ-ууд нь тухайн албан тушаалд томилогдсоноос хойш 10 (арав) хоногийн дотор өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээллийг энэхүү журмын Хавсралт №2-оор баталсан маягтын дагуу ТУЗ-ийн нарийн бичгийн даргад үнэн зөвөөр мэдүүлэх үүрэгтэй бөгөөд уг жагсаалтад өөрчлөлт орсон тухай бүрд нь 10 (арав) хоногийн дотор мэдүүлгийг шинэчилж өгнө.

	СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЖУРАМ	Дугаар: Ж-ТУЗ-147-01
---	--	-------------------------

2.3 Нэгдмэл сонирхолтой этгээдийг бүртгэх

- 2.3.1 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь Компани болон Компанийн ЭБАТ-ны нэгдмэл сонирхолтой этгээдийг энэхүү журмын Хавсралт №3-аар баталсан маягтын дагуу бүртгэн, мэдээллийн сан бүрдүүлж, өөрчлөлтийг тухай бүр тусгана.
- 2.3.2 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь Компанийн хэмжээнд хийгдэж буй хэлцлүүдэд хяналт тавих нөхцлийг бүрдүүлэх зорилгоор нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээллийг тухай бүр Хуулийн хэлтсийн даргад гаргаж өгнө.
- 2.3.3 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээллийг дараах этгээдийн хүсэлтээр болон хууль тогтоомжийн дагуу ил болгож болно.
- 2.3.3.1 Компанийн хувьцаа эзэмшигчид;
 - 2.3.3.2 ТУЗ-ийн гишүүд;
 - 2.3.3.3 Гүйцэтгэх захирал;
 - 2.3.3.4 Дотоод аудитын хэлтсийн дарга;
 - 2.3.3.5 Хөндлөнгийн аудитын байгууллага;

3. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

3.1 Сонирхлын зөрчил бүхий этгээд

- 3.1.1 Компанийн энгийн хувьцааны 20 (хорь) буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн ЭБАТ, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай дор дурдсан харилцаанд орсон бол компанитай, эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно:
- 3.1.1.1 Хэлцлийн нөгөө тал, эсхүл хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа;
 - 3.1.1.2 Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл уг хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн ЭБАТ, эсхүл энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20 (хорь)-оос дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;
 - 3.1.1.3 Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн ЭБАТ, эсхүл уг компанийн энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20 (хорь) буюу түүнээс дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;

	СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЖУРАМ	Дугаар: Ж-ТУЗ-147-01
---	--	-------------------------

3.1.1.4 Хэлцлийн үр дүнд шууд буюу шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа;

3.2 Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тавигдах шаардлага

3.2.1 Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь ТУЗ болон Гүйцэтгэх захиралд дараах зүйлсийг хэлцэл хийхээс өмнө бичгээр мэдэгдэж зөвшөөрөл авах үүрэгтэй.

3.2.1.1 Дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран энгийн хувьцааны 20 (хорь) буюу түүнээс дээш хувийг эзэмшдэг хуулийн этгээдийн болон түүний хараат болон охин компанийн талаар;

3.2.1.2 Өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь ЭБАТ-аар ажилладаг хуулийн этгээдийн болон тухайн этгээд оролцогч нь байдаг компанийн нэгдлийн бусад оролцогчийн талаар;

3.2.1.3 Компанийн хийхээр төлөвлөж байгаа хэлцлийн сонирхол бүхий этгээд болох тухайгаа;

3.2.1.4 Өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн талаар;

3.2.2 Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь уг хэлцлийн талаар шийдвэр гаргахад оролцох эрхгүй.

3.2.3 Сонирхлын зөрчилтэй хэлцлийг гагцхүү бичгээр хийнэ.

3.3 Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх

3.3.1 ТУЗ-ийн шийдвэрээр тогтмол хийгдэх сонирхлын зөрчилтэй хэлцэл

3.3.1.1 Компанийн ТУЗ нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг түргэн шуурхай, саадгүй явуулах зорилгоор жил бүрийн эхний ТУЗ-ийн хурал дээр тухайн жилд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн жагсаалт болон хэлцлийн төсвийг хараат бус гишүүдийн дийлэнх олонхын (66.67-оос дээш хувийн) саналаар батална.

3.3.1.2 Энэ журмын 3.3.1.1-д заасны дагуу батлагдсан жагсаалтад ороогүй этгээдтэй хийх болон батлагдсан төсвөөс хэтэрсэн хэлцлийг энэ журмын 3.3.2-д заасны дагуу ТУЗ-өөр шийдвэрлүүлнэ.

3.3.2 ТУЗ-ийн шийдвэрээр тухай бүр хийгдэх сонирхлын зөрчилтэй хэлцэл

3.3.2.1 Энэ журмын 3.3.1-д зааснаас бусад тохиолдолд Гүйцэтгэх захиралд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай асуудлыг

	<p align="center">СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЖУРАМ</p>	<p align="right">Дугаар: Ж-ТУЗ-147-01</p>
---	--	---

ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэх бөгөөд уг асуудлыг хэлэлцэхэд ТУЗ-ийн хараат бус гишүүд заавал оролцоно.

3.3.2.2 Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрлийг олгоход тухайн хэлцлийн хувьд сонирхлын зөрчилгүй ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхын (66.67-оос дээш хувийн) саналаар батална.

3.3.2.3 Сонирхлын зөрчилтэй хэлцлээр худалдах, худалдан авах, захиран зарцуулах эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрхийн зах зээлийн үнэ, үйлчилгээний хөлсний хэмжээг Компанийн тухай хуулийн 55-р зүйлд заасан журмын дагуу ТУЗ тогтооно.

3.3.2.4 Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай асуудлыг ХЭХ-д оруулах тухай ТУЗ-ийн шийдвэрийг ТУЗ-ийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар гаргана.

3.3.3 Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр хийгдэх сонирхлын зөрчилтэй хэлцэл

3.3.3.1 Дараах тохиолдолд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх, хараат болон охин компанид сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх буюу шаардах шийдвэрийг ХЭХ-аар хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:

- Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу компанийн ТУЗ-өөс тогтоосон хэлцлийн үнэ буюу эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрх, үйлчилгээний үнэ хөлс нь хэлцэл хийх тухай шийдвэр гаргах үеийн бүртгэлийн үнийн дүнгийн 25 (хорин тав) хувиас их байх;
- Компанийн гаргах энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдан авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаасны хэмжээ нь компанийн буюу түүний хараат хувьцаат компанийн урьд нь гаргасан энгийн хувьцааны үнийн дүнгийн 25 (хорин тав) хувиас их байх;
- ТУЗ-ийн хараат бус бүх гишүүн нь хэлцэл хийх сонирхол бүхий этгээд байх;
- Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай асуудлыг тухайн хэлцлийн хувьд сонирхлын зөрчилгүй ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхын (66.67-оос дээш хувийн) саналаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд.

	СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЖУРАМ	Дугаар: Ж-ТУЗ-147-01
---	--	-------------------------

3.3.3.2 ХЭХ-аар сонирхлын зөрчилтэй хэлцлийг хэлэлцэн шийдвэрлэхдээ хуралд оролцож байгаа сонирхлын зөрчилгүй хувьцаа эзэмшигчдийн олонхын (51-ээс дээш хувийн) саналаар шийдвэрлэнэ.

3.3.3.3 Дараах тохиолдлуудад сонирхлын зөрчилтэй хэлцлийг ХЭХ-аар батлуулах шаардлагагүй. Үүнд:

- Хэлцэл хийх сонирхол бүхий этгээд, эсхүл түүний эцэг, эх, эхнэр, нөхөр, хүүхэд, ах, эгч, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдээс зээл авах;
- Энэ журмын 3.1-д заасны дагуу хэлцэл хийх сонирхол бүхий этгээдээр тооцогдохоос өмнө Компанийн буюу түүний хараат компанийн өдөр тутмын аж ахуйн үйл ажиллагааны явцад байгуулагдсан сонирхлын зөрчилтэй хэлцлийг хувьцаа эзэмшигчдийн дараагийн ээлжит хурал болох хүртэл;
- ХЭХ хийх өдөр Компанийн буюу түүний хараат компанийн өдөр тутмын аж ахуйн үйл ажиллагааны явцад хийсэн хэлцлийг сонирхлын зөрчилтэй эсэхийг тодорхойлох боломжгүй бол ХЭХ нь хийх хэлцлийн төрөл, хэлцэл хийх этгээд болон хэлцлийн үнийн дээд хэмжээг тусгаж бусад этгээдтэй хамтран компанийн буюу түүний хараат болон охин компанийн хэрэгжүүлэх аж ахуйн үйл ажиллагааг батлах шийдвэр гаргах бөгөөд энэ нөхцөлд энэ журмын 3.3.3.1-д заасан шаардлагыг хангасанд тооцно.

3.4 Сонирхлын зөрчилтэй хэлцлийг бүртгэх

3.4.1 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ХЭХ болон ТУЗ-ийн шийдвэрээр хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийг энэхүү журмын Хавсралт №4-өөр баталсан маягтын дагуу бүртгэнэ.

3.4.2 Хуулийн хэлтсийн дарга нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд Гүйцэтгэх захирлын шийдвэрээр хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийг энэхүү журмын Хавсралт №4-өөр баталсан маягтын дагуу бүртгэнэ.

3.5 Сонирхлын зөрчилтэй хэлцлийг тайлагнах

3.5.1 Гүйцэтгэх захирал нь жил бүрийн эцэст энэ журмын 3.3.1.1-д заасны дагуу батлагдсан нэгдмэл сонирхолтой этгээдүүдтэй хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн гүйцэтгэлийг ТУЗ-ийн хуралд танилцуулна.

	<p style="text-align: center;">СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЖУРАМ</p>	<p style="text-align: right;">Дугаар: Ж-ТУЗ-147-01</p>
---	---	--

- 3.5.2 Хуулийн хэлтсийн дарга нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд Гүйцэтгэх захирлын шийдвэрээр хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн бүртгэлийг улирал бүр ТУЗ-ийн нарийн бичгийн даргад цахим байдлаар хүргүүлнэ.
- 3.5.3 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ХЭХ болон ТУЗ-ийн шийдвэрээр хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээллийг Компанийн "Олон нийтэд хүргэх мэдээллийн журам" /Ж-ТУЗ-104-02/-ын дагуу олон нийтэд мэдээлнэ.

4. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Хувьцаа эзэмшигчдийн эрх, үүрэг

- 4.1.1 Хувьцаа эзэмшигч нар нь Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн жагсаалт болон сонирхлын зөрчилтэй хэлцэлтэй танилцах, хяналт тавих эрхтэй.
- 4.1.2 Энэ журмын 3.3.3-д заасны дагуу сонирхлын зөрчилтэй хэлцлийг хэлэлцэн батлах эрх, үүрэгтэй.

4.2 ТУЗ-ийн эрх, үүрэг

- 4.2.1 ТУЗ нь ЭБАТ-уудын мэдүүлсэн нэгдмэл сонирхолтой этгээд болон сонирхлын зөрчилтэй этгээдийн мэдээлэлд үндэслэн, энэ журмын 3.3.1 болон 3.3.2-д заасны дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох эрхтэй.
- 4.2.2 ТУЗ нь сонирхлын зөрчилтэй хэлцлийг хэмжээ, үнэ, нөхцөлийг тодорхойлох эрхтэй.
- 4.2.3 ТУЗ нь энэ журмын 3.3.1.1-д заасны дагуу нэгдмэл сонирхолтой этгээдүүдтэй хийгдсэн ажил гүйлгээний гүйцэтгэлтэй жил бүр танилцан, хяналт тавьж ажиллах үүрэгтэй.
- 4.2.4 ТУЗ нь энэ журмын 3.3.3.1-д заасан тохиолдолд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх асуудлыг ХЭХ-д оруулан хэлэлцүүлэх үүрэгтэй.
- 4.2.5 ТУЗ-ийн аль нэг гишүүнд хамааралтай сонирхлын зөрчилтэй хэлцлийг тухайн гишүүнийг оролцуулахгүйгээр шийдвэрлэх үүрэгтэй.
- 4.2.6 Энэ журмын 2.2-д заасны дагуу Компанийн ЭБАТ-уудын нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдүүлэг, жагсаалтыг тухай бүр авч, бүртгэл хөтөлж, өөрчлөлтийг тусгаж байгаа эсэхэд хяналт тавих үүрэгтэй.

4.3 Эрсдэл, аудитын хорооны эрх, үүрэг

- 4.3.1 ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороо (ЭАХ) нь Компанийн хэмжээнд хийгдэж буй сонирхлын зөрчилтэй хэлцэл нь батлагдсан төсвийн хүрээнд, зах зээлийн үнэ нөхцөлөөр, хуулийн дагуу хийгдэж байгаа эсэх дээр тогтмол хяналт тавьж ажиллах үүрэгтэй.

- 4.3.2 ЭАХ нь дээрх үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой энэ журмын 3.3.1.1-д заасны дагуу батлагдсан нэгдмэл сонирхолтой этгээдүүдтэй хийгдсэн ажил гүйлгээний гүйцэтгэлтэй улирал бүр тус хорооны хурлаар дамжуулан танилцах эрх, үүрэгтэй.
- 4.3.3 ЭАХ нь жил бүр Компанийн хэмжээнд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар ХЭХ-д танилцуулах үүрэгтэй.

4.4 ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эрх, үүрэг

- 4.4.1 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь энэ журмын 2.2-д заасны дагуу ЭБАТ-уудын нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдүүлгийг хуулийн хугацаанд хүлээн авч бүртгэн, мэдээллийн сан бүрдүүлж, өөрчлөлт орсон тухай бүр шинэчлэх үүрэгтэй.
- 4.4.2 ЭБАТ нь хууль болон энэ журмаар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх тохиолдолд мэдүүлгийг хугацаандаа өгөхийг шаардах, үүрэг болгох эрхтэй.
- 4.4.3 Шаардлагатай тохиолдолд ЭБАТ-уудад нэгдмэл сонирхлын мэдүүлэг бөглөхөд зөвлөгөө өгөх үүрэгтэй.
- 4.4.4 Компанид аливаа хэлцэл хийх үед нэгдмэл сонирхолтой этгээдийн талаар лавлагаа гаргаж өгөх, Хуулийн хэлтсийн даргад бүртгэлээ тухай бүр танилцуулах үүрэгтэй.
- 4.4.5 Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээллийг энэ журмын 2.2.3-д заасан этгээдийн хүсэлтээр болон хууль тогтоомжийн дагуу ил болгох үүрэгтэй.
- 4.4.6 ХЭХ болон ТУЗ-ийн шийдвэрээр хийгдсэн сонирхлын зөрчлийн хэлцлийн мэдээллийг бүртгэх, тухайн тайлангийн хугацаанд хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээллийг олон нийтэд мэдээлэх үүрэгтэй.

4.5 Гүйцэтгэх захирлын эрх, үүрэг

- 4.5.1 Гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцлийг хууль тогтоомж болон энэ журмын хүрээнд байгуулах эрхтэй.
- 4.5.2 Гүйцэтгэх захирал нь энэ журмын 3.3.1.1-д заасны дагуу батлагдсан нэгдмэл сонирхолтой этгээдүүдтэй компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа, үйлчилгээг төсөвт тусгагдсаны дагуу зах зээлийн үнэ, нөхцөлөөр худалдах, худалдан авах үүрэгтэй.
- 4.5.3 Гүйцэтгэх захирал нь улирал бүр энэ журмын 3.3.1.1-д заасны дагуу батлагдсан нэгдмэл сонирхолтой этгээдүүдтэй хийгдсэн ажил гүйлгээний гүйцэтгэлийг

төсвийн зарцуулалтын хамт ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны хуралд танилцуулах үүрэгтэй.

4.5.4 Гүйцэтгэх захирал нь жил бүрийн эцэст энэ журмын 3.3.1.1-д заасны дагуу батлагдсан нэгдмэл сонирхолтой этгээдүүдтэй хийгдсэн ажил гүйлгээний гүйцэтгэлийг гарган, зах зээлийн харьцуулсан судалгааны хамт ТУЗ-ийн хуралд танилцуулах үүрэгтэй.

4.5.5 Гүйцэтгэх захирал нь энэ журмын 3.3.1.1-д зааснаас бусад сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар ТУЗ-д мэдэгдэх, Хуулийн хэлтсээс боловсруулсан гэрээ хэлцлийг хянах үүрэгтэй.

4.6 Хуулийн хэлтсийн даргын эрх, үүрэг

4.6.1 Компанийн ЭБАТ-уудын нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн бүртгэл, мэдээлэлтэй танилцах эрхтэй.

4.6.2 Хуулийн хэлтсийн дарга нь Компанийн хэмжээнд хийгдэж буй аливаа гэрээ хэлцлийг хянахдаа Компанийн тухай хууль, энэхүү журамд тодорхойлсон сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байгаа эсэхийг хянах үүрэгтэй.

4.6.3 Хийгдэж буй гэрээ хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох тохиолдолд сонирхлын зөрчил бүхий ЭБАТ, ТУЗ-ийн нарийн бичгийн даргад мэдэгдэх үүрэгтэй.

4.6.4 Гүйцэтгэх захирлын шийдвэрээр хийгдэж буй сонирхлын зөрчилтэй хэлцлийг бүртгэх, ТУЗ-д тайлагнах үүрэгтэй.

4.6.5 Шаардлагатай тохиолдолд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх, цаашид үүсч болох эрх зүйн үр дагаврын талаар Гүйцэтгэх захирал болон ЭБАТ-уудад зөвлөмж бэлтгэж танилцуулах үүрэгтэй.

4.6.6 ТУЗ-өөс сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах тухай зөвшөөрөл гарсан тохиолдолд холбогдох хэлцлийг хууль тогтоомж, энэхүү журам болон ТУЗ-ийн тогтоолд нийцүүлэн хянах үүрэгтэй.

4.7 ЭБАТ-уудын эрх, үүрэг

4.7.1 ЭБАТ-ууд нь энэ журмын 2.2-д заасны дагуу нэгдмэл сонирхолтой этгээдийн талаарх мэдүүлгийг гаргахад ТУЗ-ийн нарийн бичгийн даргаас заавар зөвлөмж авах эрхтэй.

4.7.2 Өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдүүлгийг хууль тогтоомж болон энэхүү журамд заасан хугацаанд ТУЗ-ийн нарийн бичгийн даргад үнэн зөвөөр мэдүүлэх үүрэгтэй бөгөөд уг жагсаалтад өөрчлөлт орсон тухай бүрд нь 10 (арав) хоногийн дотор мэдүүлгийг шинэчилж өгөх үүрэгтэй.

	СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЖУРАМ	Дугаар: Ж-ТУЗ-147-01
---	--	-------------------------

5. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

5.1 Хяналт тавих

- 5.1.1 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон Хуулийн хэлтсийн дарга нь энэхүү журмын биелэлтэд өдөр тутам хяналт тавьж ажиллана.
- 5.1.2 ЭАХ нь Компанийн хэмжээнд хийгдэж буй сонирхлын зөрчилтэй хэлцэл нь батлагдсан төсвийн хүрээнд, зах зээлийн үнэ нөхцөлөөр, хуулийн дагуу хийгдэж байгаа эсэх дээр улирал бүр тус хорооны хурлаар дамжуулан хяналт тавьж ажиллана.
- 5.1.3 ТУЗ нь энэхүү журмын биелэлтийг хянаж, үнэлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчилнэ.

5.2 Хариуцлага хүлээлгэх

- 5.2.1 Энэ журмын 3.1-д заасан сонирхлын зөрчил бүхий этгээд нь энэ журмын 3.2, 3.3 дугаар зүйлийн шаардлага, журам зөрчсөний улмаас Компани буюу түүний хараат болон охин компанид учруулсан хохирлын хэмжээгээр, эсхүл хэлцлийн үр дүнд авсан зүйлээс олсон ашгийн хэмжээгээр хариуцлага хүлээнэ.
- 5.2.2 Сонирхлын зөрчилтэй хэлцлийн улмаас компани, түүний хараат болон охин компанид учирсан хохирлыг гэм буруутай этгээд өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.
- 5.2.3 Компанийн энгийн хувьцаа эзэмшигч болон компанийг төлөөлөх ЭБАТ энэ журмын 5.1.2-д заасан хариуцлага хүлээлгэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

6. БУСАД


6.1 Бусад зүйл

- 6.1.1 Уг журамд тусгаагүй аливаа харилцааг Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржээс гаргасан бусад дүрэм, журамд заасны дагуу зохицуулна.

ТӨГСӨВ.

7. ХАВСРАЛТ

Хавсралт №1. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх процесс зураглал



Хавсралт №2. ЭБАТ-ны нэгдмэл сонирхлын мэдүүлэг




ГОВЬ ХК-ИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ
НЭГДМЭЛ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ

Компанийн тухай хуулийн 85.1, Говь ХК-ийн "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам"-ын 2.2-д заасны дагуу компанийн эрх бүхий албан тушаалтан нь тухайн албан тушаалд томилогдсоноос хойш 10 хоногийн дотор өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргаж, ТУЗ-ийн нарийн бичгийн даргад өгөх бөгөөд уг жагсаалтад өөрчлөлт орсон тухай бүрд нь 10 хоногийн дотор мэдүүлгийг шинэчилж өгнө.

I. МЭДҮҮЛЭГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Ургийн овог:
 Эцэг/ эхийн нэр:
 Өөрийн нэр:
 Төрсөн он, сар, өдөр:
 Төрсөн аймаг, хот:
 Регистрийн дугаар:
 Оршин суугаа хаяг:
 Утасны дугаар:
 И-мэйл хаяг:
 Эзэмшиж буй Говь ХК-ийн хувьцааны тоо:



II. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛД ТОМИЛОГДСОН ТУХАЙ

Байгууллагын нэр:	Говь ХК
Харьяалах газар, хэлтэс, нэгжийн нэр:	
Албан тушаал:	
Тухайн албан тушаалд томилогдсон/сонгогдсон огноо:	
Мэдүүлэг гаргах үндэслэл:	<input type="checkbox"/> анх удаа мэдүүлэх <input type="checkbox"/> шинээр томилогдсон <input type="checkbox"/> мэдүүлэгт өөрчлөлт оруулах
Одоо ажиллаж байгаа болон сүүлийн 2 жил ажилласан байгууллага, албан тушаал:	
Таны одоогийн хашиж байгаа ажил, албан тушаал төрийн албанд хамаардаг бол аль төрөлд хамаарахыг сонгоно уу.	<input type="checkbox"/> төрийн улс төрийн албан тушаал <input type="checkbox"/> төрийн захиргааны албан тушаал <input type="checkbox"/> төрийн тусгай албан тушаал <input type="checkbox"/> төрийн үйлчилгээний албан тушаал

	СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЖУРАМ	Дугаар: Ж-ТУЗ-147-01
---	--	-------------------------

III. ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ /Хамт амьдарч байгаа болон ерхийн бүртгэлд бүртгэлтэй хүмүүсийг бичнэ./

Таны юу болох	Овог, нэр	Регистрийн дугаар	Төрсөн аймаг, хот, сум	Ажиллаж байгаа байгууллага, сурч байгаа сургууль, Эрхэлж буй ажил, албан тушаал	Эзэмшиж буй Говь ХК-ийн хувьцааны тоо

IV. МЭДҮҮЛЭГЧТЭЙ ХАМААРАЛ БҮХИЙ ЭТГЭЭД /ерх тусгаарласан эцэг, эх, хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, эхнэр /нөхөр/, хамтран амьдрагчийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүүг бичнэ./

Ямар хамааралтай болох	Овог, нэр	Регистрийн дугаар	Ажиллаж байгаа байгууллага, сурч байгаа сургууль, Эрхэлж буй ажил, албан тушаал	Бизнес, үйл ажиллагааны чиглэл	Эзэмшиж буй Говь ХК-ийн хувьцааны тоо

V. НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭД /ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийн талаар бичнэ./

Ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбогдсон хувь хүний нэр	Ямар харилцаатай болох/байсан	Регистрийн дугаар	Ажиллаж байгаа/байсан байгууллага, албан тушаал	Тайлбар (Үйл ажиллагааны чиглэл, зорилго)	Эзэмшиж буй Говь ХК-ийн хувьцааны тоо
Ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбогдсон хуулийн этгээдийн нэр	Ямар хамааралтай болох	Регистрийн дугаар	Эрхэлж байгаа /байсан/ үйл ажиллагааны төрөл	Тайлбар (Үйл ажиллагааны чиглэл, зорилго)	Эзэмшиж буй Говь ХК-ийн хувьцааны тоо

	СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЖУРАМ	Дугаар: Ж-ТУЗ-147-01
---	--	-------------------------

VI. КОМПАНИ, НӨХӨРЛӨЛ, ХОРШООНД ОРУУЛСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Хуулийн этгээдийн нэр, хэлбэр	Хувьцааны тоо	Нэгж хувьцааны үнэ /төгрөг/	Хуулийн этгээдийн нийт дүрмийн сан	Нөгдоп хувь

..... овогтой миний бие өөрийн нэгдмэл сонирхлын байдлыг үнэн зөв мэдүүлсэн бөгөөд компанийн эрх бүхий албан тушаалтны хувьд Компанийн тухай хуулийн 84.4-т заасан дараах үүргийг чандлан сахиж ажиллахаа баталж байна. Үүнд:

1. Хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх
2. Үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх
3. Компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах
4. Шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж, сонирхлын зөрчил үүсэхээр бол энэ тухайгаа тухай бүр мэдэгдэх
5. Өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хөндлөнгийн этгээдээс бэлэг, урамшуулал авахгүй байх
6. Компанийн нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулах, хувийн сонирхлын зорилгоор ашиглахгүй байх

Гарын үсэг /баталгаат/: /

Огноо:

	СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЖУРАМ	Дугаар: Ж-ТУЗ-147-01
---	--	-------------------------

Хавсралт №3. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдийг бүртгэх хуудас



ГОВЬ ХК-ИЙН НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДИЙГ БҮРТГЭХ ХУУДАС

I. НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭД

№	Хуулийн этгээдийн нэр	Регистрийн дугаар	Үйл ажиллагааны чиглэл	Нэгдмэл сонирхолтой этгээдэд тооцогдох холбоо хамаарал (хуулийн үндэслэл)	Бүртгэлтэй улс	Говь ХК-ийн хувьцааны эзэмшил		
						Төрөл	Тоо	Эзэмшлийн хувь

II. НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ХУВЬ ХҮН

№	Овог	Нэр	Регистрийн дугаар	Холбоо хамаарал (хуулийн үндэслэл)	Иргэншил	Говь ХК-ийн хувьцааны эзэмшил		
						Төрөл	Тоо	Эзэмшлийн хувь

Хавсралт №4. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг бүртгэх хуудас



ГОВЬ ХК-ИЙН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ БҮРТГЭХ ХУУДАС

№	Огноо	Гэрээ хэлцлийн утга	Үнийн дүн	Хэлцлийн нөгөө тал	Гэрээний нөхцөл	Эхлэх огноо	Дуусах огноо	Хэлцэл баталсан тогтоол, шийдвэрийн дугаар	Сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох хуулийн үндэслэл

2023 он 11 сар 20 өдөр

Дугаар 37

Улаанбаатар хот

Үл хөдлөх хөрөнгө борлуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3, 76 дугаар зүйлийн 76.1.6, 76.1.17, 89 дүгээр зүйлийн 89.1, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсгийг удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

Нэг. Говь ХК-ийн доорх үл хөдлөх хөрөнгийг “Улаанбаатар Принт” ХХК-д худалдан борлуулахыг Гүйцэтгэх захирал /Ц.Баатарсайхан/-д зөвшөөрсүгэй.

№	Үл хөдлөх хөрөнгийн нэр	Байршил	Талбай	Борлуулах үнийн дүн
1	Үйлдвэрийн барилга /үл хөдлөхийн гэрчилгээний дугаар: 000937453/	Төв аймаг, Сэргэлэн сум, Бараат уулын зүүн талд	1,200 м.кв	1,407,533,260 төгрөг
2	Үйлдвэрлэлийн барилга, байгууламжийн зориулалттай газар /нэгж талбарын дугаар: 4109052358/		33,500 м.кв	25,000,000 төгрөг
	Нийт			1,432,533,260 төгрөг

Хоёр. Дээрх хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох тул Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэн баталсугай.

Гурав. Үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулахтай холбоотой гэрээ хэлцэлд гарын үсэг зурж баталгаажуулах эрхийг Гүйцэтгэх захирал /Ц.Баатарсайхан/, Хуулийн хэлтсийн дарга /Ц.Цасчихэр/, Инженерийн байгууламжийн албаны дарга /О.Мөнхжаргал/ нарт тус тус олгосугай.

ТУЗ-ийн ДАРГА:

ТУЗ-ийн ХАРААТ БУС ГИШҮҮД:



Д.ГЭРЭЛМАА

А.ЖАРГАЛМАА

ТАКЭШИ КАМБЭ

Д.ХҮРЭЛБААТАР

20~~23~~ он ~~11~~ сар ~~20~~ өдөр

Дугаар ~~38~~

Улаанбаатар хот

АНУ дахь охин компанийн Гүйцэтгэх захирлыг өөрчлөх тухай

Говь ХК-ийн АНУ дахь охин компани болох “GOBI MONGOLIAN CASHMERE USA” ХХК-ийн Гүйцэтгэх захирлыг өөрчлөх тухай асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Компанийн дүрмийн 6.3 дугаар зүйлийн 6.3.3.2 дахь хэсгийг удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

Нэг. Говь ХК-ийн охин компани болох “GOBI MONGOLIAN CASHMERE USA” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Чулуунбат овогтой Үнэнбатын хөдөлмөрийн гэрээг 2023 оны 11-р сарын 30-ны өдрөөр дуусгавар болгож ажлаас чөлөөлсүгэй.

Хоёр. “GOBI MONGOLIAN CASHMERE USA” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар Баатарсайхан овогтой Амарсайханыг 2023 оны 12-р сарын 01-ний өдрөөс эхлэн томилсугай.

Гурав. Чулуунбат овогтой Үнэнбаттай байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцлах болон Баатарсайхан овогтой Амарсайханыг “GOBI MONGOLIAN CASHMERE USA” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар томилохтой холбоотой үйл ажиллагааг Монгол улсын болон АНУ-ын хууль, дүрэм, журамд нийцүүлэн зохион байгуулан ажиллахыг Говь ХК-ийн Гүйцэтгэх захирал /Ц.Баатарсайхан/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ГЭРЭЛМАА